

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр, Мягмар гараг*

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-3
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	4-32
<hr/>	
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай/	5-6
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/	6-7
3.Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээлэл сонсох	7-32

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны  
05 дугаар сарын 05-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 28 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 35 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.*

*Томилолттой: Х.Баасанжаргал, Ц.Сандаг-Очир;  
Чөлөөтэй: Э.Батшугар, Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар,  
М.Нарантуяа-Нара, Б.Тулга;  
Эмнэлгийн чөлөөтэй: С.Цэнгүүн.*

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хэлэлцэх асуудлын дарааллын 1 дүгээрт орсон Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаарт орсон Дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хойшлуулах горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Д.Цогтбаатар нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

***Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Цогтбаатар:** “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5  
Бүгд: 16  
68.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Цогтбаатар:** “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 5  
Бүгд: 18  
72.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээлэл сонсох***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга Э.Ганчулуун, мөн газрын Эрүүгийн цагдаагийн албаны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн дарга Ц.Дашзэвэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг, Хяналт шалгалтын газрын зөвлөх Ж.Монголжингоо, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн нар байлцав.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн дарга Ц.Дашзэвэг танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Да.Цогтбаатар, С.Одонтуяа, О.Алтангэрэл, Х.Булгантуяа, О.Батнайрамдал,

С.Эрдэнэболд, Б.Баярбаатар нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга Э.Ганчулуун, мөн газрын Эрүүгийн цагдаагийн албаны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн дарга Ц.Дашзэвэг нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар 11 цаг 10 минутаас хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Х.Булгантуяа, С.Эрдэнэболд, Б.Баярбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Засгийн газрын мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 12 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 46 минут үргэлжилж, ирвэл зохих 28 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 12 цаг 21 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим  
10 цаг 35 минут.

### ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Цогтбаатар:** Энэ өдрийн мэндийг хүргэе Байнгын хорооны гишүүддээ. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хороо /ХЗБХ/-ны 2026 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Хуралдааны ирц 57,1 хувьтайгаар бүрдсэн байна. Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Оюунсайханы Алтангэрэл, Халтмаагийн Баттулга, Дамбын Батлут, Баярмагнайн Баярбаатар, Жудагийн Баярмаа, Гонгорын Дамдинням, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Даваахүүгийн Пүрэвдаваа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар гэсэн ийм гишүүдийн ирцтэйгээр ирц бүрдсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр төлөвлөгдсөн байгаа уг нь 5 асуудал байгаа. 1 дүгээр асуудал, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлгийн асуудал байгаа. 2 дугаар асуудал, Дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа. 3 дугаар асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай тухай. 4 дүгээр асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл Цаглавар батлах тухай. 5 дугаар асуудал, Хүн худалдаалах гэмт хэрэг /ХХГХ/-тэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газар /ЗГ/-ын мэдээллийг сонсох гэсэн ийм 5 асуудал байгаа.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрсээ өгнө үү? Хэлэлцэх асуудал дээр Тэмүүжин гишүүнд санал байгаа юм байна. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

**Х.Тэмүүжин:** Байнгын хорооны хэлэлцэх асуудлын нэг дээр байгаа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой асуудал дээр өчигдөр ажлын хэсэг ерөнхийдөө шийдвэрээ гаргаж, цаасаа эцэслэсэн. Энэ хуулийн өөрчлөлттэй холбоотой асуудал дээр эрх ашиг нь хөндөгдөж байгаа хамгийн том бүлэг нь өөрөө нөгөө хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотой, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл тодорхой байр сууриуд илэрхийлээд байгаа. Тэгээд ажлын хэсгээс эцэслэсэн цаастай холбоотой асуудлаар бид ингээд авч үзэх хэрэгцээ байна нэг, өөрсдөө судлах хэрэгтэй байна, бас санал бодлоо илэрхийлэх хэрэгтэй байна, дотроо хэлэлцүүлэг хийх хэрэгтэй. Яагаад гэвэл

манай байгууллагыг төлөөлөөд 1, 2 хүн энэ ажлын хэсэгт байгаа боловч цаашаагаа ардаа байгаа сэтгүүлчид тэр нөгөө үзэл санаагаараа нэгдсэн мэргэжилтнүүдтэйгээ энэ хуулийн төслийг хэлэлцүүлэхгүй бол бид шууд төлөөлж асуудлыг ярих боломжгүй байгаа учраас хугацаа өгөөч гэсэн.

Тийм учраас энэ удаагийн Байнгын хорооноос хэлэлцэх асуудлаас хасаад, ирэх долоо хоногт шилжүүлээд оруулаад, ер нь сэтгүүлчдэдээ долоо хоногийн асуудлыг хэлэлцэх, дотроо нэгдсэн байр суурьтай болох тэр чиглэл дээр нь хугацаа өгье гэсэн саналтай байгаа юм. Горим санал гаргаж байгаа.

**Д.Цогтбаатар:** Горимын санал ойлголоо. Тэгвэл та нар илүү гүйцээж боловсруулах зайлшгүй шаардлага гараад байгаа юм байна тийм ээ? Ойлголоо. Тийм ч байгаа байх, наадах чинь бас над дээр ч гэсэн хүмүүс орж ирээд энэ дээр нэг жоохон гүйцээн боловсруулах асуудлууд байгаа шүү гээд яриад байгаа юм.

Энэ дээр би, энэ чинь тус тусдаа саналаа хураагаад явна. Тэгэхдээ би нэг юу яачихъя, горимын би бас нэг санал гаргахгүй бол энэ 2 дугаар асуудал дээр зүгээр техникийн хувьд бэлэн биш байна энэ Дэд хороо байгуулах юун дээр. Тэгэхлээр энийг энэ удаа хойшлуулахгүй бол жишээлбэл хүмүүсийнхээ нэрсийг аль, аль бүлгээс надад ирүүлээгүй байж байгаа юм. Монгол Ардын нам /МАН/-ын зүгээс ч гэсэн бүлгийн энэ дэд хороонд орох гишүүдийнхээ нэрсийг өгөөгүй байгаа болохлоор энийг зүгээр хэлэлцэх ямар ч техникийн нөхцөл бололцоо хангагдаагүй байна. Энэ 2 асуудлаар тэгвэл горимын санал хураагаад явчихъя. Тэгвэл юу яая, энэ эхний 2 асуудлыг энэ удаа хойшлуулаад, 3 асуудлаа үлдсэн 3 асуудлаа хэлэлцээд явъя гэсэн горимын санал гаргаж байна. Энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая. Санал хураахад бэлдээрэй гишүүдээ. Санал хураалт. 56,3 хувиар санал дэмжигдлээ. Ингээд 3 дугаар асуудлаасаа асуудалдаа ороод явъя.

***Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай/***

Шүүхийн ерөнхий зөвлөл /ШЕЗ/-ийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, 2026 оны дугаар сарын дугаар өдөр, дугаар, Улаанбаатар хот. ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай. Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1.2 дахь заалтыг үндэслэн ХЗБХ-ноос тогтоох нь:

ШЕЗ-ийн шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалтад оролцох иргэний хүсэлт, баримт бичгийг 2026 оны 5 дугаар сарын 7-ны өдрөөс 2026 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл хугацаанд хүлээн авч бүртгэхээр тогтсугай.

2.Сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд мэдээлэх, нэр дэвшигчийн хүсэлт, материалыг хүлээн авах ажлыг холбогдох тогтоомж, хууль тогтоомжийн

дагуу зохион байгуулахыг ХЗБХ Цогтбаатарт даалгасугай. ХЗБХ-ны дарга Цогтбаатар гэсэн ийм юу тогтоол байна.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Тэгвэл байхгүй байна гэж үзлээ. Гишүүд энэ юунд санал хураалтад бэлтгэе. Гишүүдээ санал хураалтдаа бэлтгээрэй.

ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 68,8 хувиар санал дэмжигдлээ. Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

10.44 цаг

### ***Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/***

Дараагийн асуудалдаа оръё. Цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, 2026 оны дугаар сарын дугаар өдөр, дугаар, Улаанбаатар хот. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард ХЗБХ-ны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийг үндэслэн ХЗБХ-ноос тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай, 179 дүгээр захирамж болон Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт заасан ХЗБХ-ны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх хяналт шалгалт хийх цаглаварыг хавсралтаар баталсугай.

2.Хэлэлцэх хугацааг хуульд тусгайлан заасан болон бусад Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн ХЗБХ-ны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3.Энэ тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын ХЗБХ Цогтбаатарт, хэлэлцэх асуудлын бэлтгэл хангах, мэргэжил арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар Л.Өлзийсайханд үүрэг болгосугай. ХЗБХ-ны дарга Цогтбаатар гэсэн ийм томъёололтой тогтоол байна. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Алга байна. Саяын энд Цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг сая уншиж танилцуулсан тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт, манайхан бэлдээрэй. Санал хураалт. 72,2 хувиар санал дэмжигдлээ.

10.47 цаг

**Гурав.Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээлэл сонсох**

Дараагийн асуудалдаа орёе. 3 дугаар асуудал ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх ЗГ-ын мэдээллийг сонсьёе. ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг Цагдаагийн ерөнхий газар /ЦЕГ/-ын Тэргүүн дэд дарга, цагдаагийн хурандаа Э.Ганчулуун танилцуулна.

Хуралдаанд ирж оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. С.Амарсайхан, сайд байхгүй байх шиг байна. Н.Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яам /ХЗДХЯ/-ны Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/, Э.Ганчулуун ЦЕГ-ын Тэргүүн дэд дарга, цагдаагийн хурандаа, Ц.Дашзэвэг Эрүүгийн цагдаагийн алба /ЭЦА/-ны ХХГХ-тэй тэмцэх тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа. ТНБД нь хаана байна вэ? Сайд нь байхгүй байна, би тэрийг ойлгож байна. ТНБД нь ядаад байх ёстой байх энд. Яагаад гэвэл хэлэлцэх гэж байгаа асуудал чинь чухал асуудал байна шүү дээ.

Нэг юу би засаад хэлчихье. Энэ нөгөө дэд хорооны дээр би түрүүн 2 намаас нэр ирээгүй гээд хэлсэн. АН-ын бүлгээс нэр ирчихсэн байгаа юм байна шүү. МАН-аас нэр ирээгүй байгаа. Би энэ фактыг нь засаад хэлчихсэн нь зөв байх. Төрийн нарийн ядаад байх ёстой, уг нь Байнгын хороог хүндэтгээд сайд нь ч байх ёстой. Энд 27 гишүүн. Дэд дарга нь, Төрийн нарийн бичиг, зүгээр танилцаж байгаад, ТНБД орж ирж байгаа юм байна. Тэгэхлээр ер нь зүгээр ажлаа эхлээд, танилцуулгаа явуулж байя. ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг ЦЕГ-ын Тэргүүн дэд дарга, цагдаагийн хурандаа Ганчулуун танилцуулна. 5 дугаар микрофон уу? 5 дугаар микрофон өгье тэгье.

**Ц.Дашзэвэг:** Та бүхний амрыг эрье. Цагдаагийн байгууллагаас ХХГХ-тэй тэмцэх тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Дашзэвэг миний бие мэдээлэл танилцуулна. ХХГХ-тэй тэмцэх нэгжийн Монгол Улсын ЗГ-ын 2017 оны 5 сарын 24-ний өдрийн 148 дугаар тогтоолоор Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд анх ХХГХ-тэй тэмцэх нэгжийг 6 албан хаагчийн орон тоотой баталсан. Үүнээс хойш ХЗДХЯ-наас 2025 онд ХЗДХ-ийн тухайн нэгжийн чадавхыг үнэлэх, ажлын байрны шинжилгээ хийх, бүтэц, орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна гэж үзэн 2025 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн А66 дугаар тушаалаар дахин бүтэц орон тоог 9 орон тоотой болгож, өргөжүүлсэн байгаа.

Цагдаагийн байгууллагаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Эрүүгийн хуулийн тусгай ангийн дараах зүйлд ХХГХ-тэй тэмцэх нэгжид харьяалуулж, мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг. Үүнийг Монгол Улсын ерөнхий прокурор /УЕП/-ын 2024 оны 5 сарын 8-ны өдрийн А73 дугаар тушаалаар 4 бүлгийн 11 зүйл, ангийг харьяалуулан мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар харьяалал тогтоож өгсөн байна. ХХГХ-тэй тэмцэх ажлын чиглэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 4 бүлгийн 11 төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх гүйцэтгэх ажлын шугамаар тэмцэх, Монгол Улсын ХЗДХ-ийн сайдын 2017 оны 3 сарын 3-ны өдрийн А49 тоот тушаалаар батлагдсан хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх журамд хяналт тавих, ЭЦА-ны даргын Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэх зохион байгуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай

2021 оны маш нууц MN11/01 албан даалгаврын биелэлт, үр дүнг тооцон улсын хэмжээнд үр дүнг тооцон ажилладаг.

Мөн төрийн болон төрийн бус байгууллага /ТББ/, олон улсын байгууллагуудтай хамтран ХХГХ-ээс хохирогч хамгаалал, гэрч, хохирогчийг хамгаалах, ТББ болон холбон зуучлах эрх ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр урьдчилан сэргийлэх сургалт, соён, гэгээрлийн ажлын чиглэлээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах ажлын албаны даргын 2021 оны 7 сарын 7-ны өдрийн А17 дугаар тушаалаас болсон салбар дундын хамтарсан багаар ажиллах. Монгол Улсад ХХГХ-ийн дотоод нөхцөл байдал бол хуучин Улаанбаатар хотын тодорхой цэг байршлуудад биеэ үнэлэх зохион байгуулах хэлбэр ингээд гудамж талбайд үйлдэгддэг байсан бол 2021 оноос хойш цахим хэлбэрт бол энэ шилжсэн байж байгаа.

Мөн Монгол Улс руу чиглэсэн гадаадын иргэдийн аялал жуулчлал урсгал нэмэгдэж байгаатай холбоотой гадаадын иргэдээс далд хэлбэрээр Монгол Улсад энэ төрлийн гэмт хэргийг зохион байгуулсан, санхүүжүүлсэн хэргүүд одоо бүртгэгдэж эхэлсэн. Үүн дээр жишээ дурдвал, тийм байгаа байх, зүүн өмнөд азийн ... парк буюу БНХАУ-ын, дотоод нөхцөл байдал дээр энэ гадаадын иргэдээс энэ аялал жуулчлал хөгжсөнтэй холбоотой Бүгд Найрамдах Хятад Ард улс /БНХАУ/-ын болон Бүгд Найрамдах Солонгос улс /БНСУ/-ын иргэдээс Монгол Улсад тайчих үзүүлбэртэй шөнийн цэнгээний газрууд, мөн ширээний охидтой караоке зэрэг энэ халхавчлан далд хэлбэрт биеэ үнэлэх зохион байгуулах, ХХГХ үйлдэж байсныг өнгөрсөн онуудад цагдаагийн байгууллагаас илрүүлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байгаа.

Сүүлийн 6 жилийн байдлаар Монгол Улсад бүртгэгдсэн ХХГХ-ийн нөхцөл байдлыг танилцуулъя. Нийт 92 холбогдогчтой 65 хэрэгт ХХГХ бүртгэгдэн, мөрдөн шалгах ажиллагаа явуулан шалгагдсан. Үүнээс нийт 92 хохирогчоос хохирогчийн 54 буюу 58 хувь нь насанд хүрээгүй хохирогчид энэ ХХГХ-ийн хохирогчид болсон байна гэсэн ийм сүүлийн 6 жилийн байдлаар тоон статистик гарсан байж байгаа. Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16.8 дугаар зүйл хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, Эрүүгийн хуулийн 16.9 дүгээр зүйл хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах заасан гэмт хэргүүд цахим орчинд хүүхэд хохирсон гэмт хэрэгт сүүлийн 5 жилийн хугацаанд цагдаагийн байгууллагад 141 хэрэг бүртгэгдэн мөрдөн шалгах ажиллагаа явагдсан байна.

Гадаад нөхцөл байдлын талаар. Сүүлийн үед биеэ үнэлдэг охид эмэгтэйчүүдийг Зүүн Өмнөд Азийн аялал жуулчлалын бүс орнууд руу өндөр цалинтай ажиллаж зуучлах нэрийдлээр хуурч мэхлэх, биеийг нь үнэлүүлэх, албадан хөдөлмөр буюу Монгол Улс руу чиглэсэн цахим залилангийн гэмт хэрэг үйлдэгдэж байгаа тохиолдлууд бүртгэгдсэн. Мөн кейс дурдвал БНХАУ-ын гэмт бүлэглэлийн санхүүжилтээр байгуулсан энэ КК парк гээд бүсэд Мьянмар улсад Монгол Улсын 12 иргэнийг хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлэн зорчих эрхийг нь хязгаарлан хөдөлмөрийн мөлжлөгт үржүүлж байсан гэмт хэрэг бүртгэгдэн ингээд мөрдөн шалгах ажиллагаагаар бол тухайн 12 иргэнийг тухайн бүс нутаг дээр зорчих эрхийг нь хязгаарлан Монгол Улс руу чиглэсэн телеграм залилангийн гэмт хэрэг үйлдүүлж байсан нөхцөл байдал тогтоогдоод, улмаар данс, бусад нотлох баримтуудыг цуглуулсны үндсэн дээр тухайн иргэд маань тухайн гэмт бүлэглэлдээ өөрсдөө элсэн, сардаа нэг 4-өөс 5 мянган долларын ийм цалин хөлс олдог, Монгол Улсаас дахин энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх хохирогчдыг тухайн бүс нутаг руу зуучлах,

холбон зуучлах ийм төрлийн гэмт хэрэг үйлдэж байсан этгээдүүдийг Монгол Улсын хилээр нэвтрэх үед нь дайчлан баривчлан мөрдөн шалгах ажиллагаа явуулж ажиллаж байна.

Монгол Улсаас сүүлийн 10 жилийн хугацаанд гадаад улсад бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөгт өртөж хохирсон нийт 94 хохирогчийг Гадаад харилцааны яам /ГХЯ/-ны Консулын газар, Тагнуулын ерөнхий газар /ТЕГ/-тай хамтран эх оронд нь аюулгүй авчирсан байж байна. Эндээс оруулж ирсэн энэ гадаад улсаас өртөж хохирсон хохирогчдоос үзэхээр нийтлэг БНХАУ, Мьянмар, Малайз гэсэн энэ бүс нутгуудад дийлэнх энэ гадаад улсад Монгол Улсын иргэдэд өртөж хохирч байна гэсэн ийм тоон судалгаа та бүхэн энэ дэлгэцээс харж болно.

ХЗДХ-ийн сайдын 2017 оны А49 дүгээр тушаалаар Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, хяналт тавих журамд цагдаагийн байгууллагаас хяналт тавьж, Хил хамгаалах ерөнхий газар /ХХЕГ/ мөн бас давхар Шалган нэвтрүүлэх албан дээр хяналт тавьж ингэж ажилладаг. Сүүлийн 5 жилийн байдлаар 1382 иргэн, байгууллагаас ирүүлсэн хүсэлтэд 8381 иргэнд Монгол Улсын хил нэвтрэх зөвшөөрөл олгож ажилласан. Сүүлийн жилүүдэд энэ сурагчдын амралттай холбоотой урлаг соёл, спортын тэмцээн уралдаанд явж байгаа насанд хүрээгүй хүүхдүүдийг Монгол улсын хилээр нэвтрүүлэх энэ хүсэлтүүд бол нэлээдгүй нэмэгдсэн. Энэ тухайн нэгж дээр бол яг энэ Монгол Улсын хилээр нэвтрүүлэх насанд хүрээгүй хүүхдийг хариуцан авч явж байгаа итгэмжилсэн төлөөлөгчийг хянаж шалгаад, ХХЕГ-ын шалган нэвтрүүлэх алба руу нэвтрүүлэх боломжтой байна гэсэн энэ зөвшөөрлийг олгодог байна.

Энэ зөвшөөрөл бол одоо яг цагдаагийн байгууллага дээр цаасан хэлбэр дээр явж байгаа. Иргэд маань нотариатаар оруулдаг гэдэг юм уу, нотариатын гэрчилгээгээ хуулбартайгаа, тухайн сургалтын урилгатайгаа гэсэн ийм цаасан хэлбэртэй оруулж байгааг бид энэ 2025 онд хэрэгжүүлсэн ХУМТРА сан буюу ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ашигладаг ХУМТРА сандаа ИМонголиа системээр иргэдээсээ энэ хүсэлтийг авдаг байя ингээд цахим өргөжүүлэлтийг хөгжүүлье гээд ЦЕГ-ын Стратеги бодлого, инновац, хөгжлийн албан дээр программ хөгжүүлэлтийн ажил бүрэн хангагдаад дууссан. И Монголиа академи дээр бид хүсэлтээ өгөөд, иргэдээс энэ хүсэлтийг ирүүлэх холбоос программын бичилтийн ажлаа 5 сардаа дуусгаад, энэ программ хангалтын ажлыг бол 5 сардаа хэрэгжүүлье гэсэн ийм зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын ЗГ болон Америкийн Нэгдсэн улс /АНУ/-ын Төрийн департамент хооронд 2020 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Монгол Улсад хүүхдийг бэлгийн мэргэжлийн зорилгоор худалдаалах, албадан хөдөлмөр эрхлүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээг байгуулан 4 жилийн хугацаатай хэрэгжүүлсэн. Энэ төсөл маань 2024 онд 4 жилийн хугацаанд дуусгавар боловч дахин 1 сарын, 1 жилийн хугацаатайгаар сунган, ингээд 5 жилийн хугацаатай хэрэгжээд одоогийн байдлаар зогссон байж байгаа. Мөн цаашид үргэлжлүүлэх эсэх саналыг АНУ-ын Төрийн департаментад уламжилсан. Одоо АНУ-аасаа шийдвэр ирээгүй байна гэсэн ийм мэдээлэлтэй байна.

Компакт гэрээний төслийн хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл ажлын албаны даргын 2021 оны 7 сарын 7-ны А17 дугаар тушаалаар төрийн 12, төрийн бус 1, нийт 16 гишүүнтэйгээр энэ ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах, ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх тусламж, үйлчилгээ,

төрийн үйлчилгээг хүргэх зорилгоор салбар дундын хамтарсан багийг байгуулан ажиллаж байгаа. Энд цагдаагийн байгууллагаас нийт 2 албан хаагч 4 жилийн хугацаанд тогтвор суурьшилтай ажиллаж байна.

Мөн төслийн хүрээнд хүүхэд хамгааллын хүүхдээс мэдүүлэг авах 5 өрөөг тохижуулсан. Өнөөдрийн байдлаар 3289 хүүхдээс мэдүүлэг авсан байна гэсэн ийм тоон үзүүлэлт гарсан. Энэ мэдүүлэг авах өрөөг тохижуулах болсон шалтгаан нь юу юм бэ гэхээр дийлэнх Монгол Улсад бүртгэгдэж байгаа ХХГХ-ийн хохирогчид маань насанд хүрээгүй хүүхдүүд байдаг. Тэгээд энэ ХХГХ-ийн насанд хүрээгүй хохирогч нь бэлгийн болон сэтгэл санааны, сэтгэл зүйн ингээд олон төрлийн ийм айдаст автдаг, ийм сэтгэл зүйн ийм тогтворгүй байдалд ордог учраас энэ тухайн насанд хүрээгүй охид эмэгтэйчүүдээс мэдүүлэг авах өрөөг орчин, насны ангилалд нь тохирсон байдлаар ийм тохижуулах нь хэргийн нотлох баримт үнэн зөв мэдүүлэг өгөх боломжийг бүрдүүлэх юм байна гэж үзсэнээс 5 өрөөг ингээд тохижуулж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Мөн Монгол Улсын ЗГ болон Төрийн департаментын хооронд байгуулсан Хүүхэд хамгааллын түншлэлийн гэрээний хүрээнд Хүүхэд хамгаалах төслөөс тус байгууллагаас 15 албан хаагчийг форензик ярилцлагын арга буюу энэ чиглэлээр мэдлэг эзэмшүүлэх үндэсний сурагч багшийг бэлтгэсэн байж байгаа. Энэ бол хохирогч.../минут дуусав/

**Д.Цогбаатар:** 5 дугаар микрофон гүйцээгээд өгье.

**Ц.Дашзэвэг:** Цагдаагийн байгууллагаас ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр дараах саналыг танилцуулж байна. 1 дүгээрт, ХХГХ-ийг хил дамнан илрүүлэх, таслан зогсоох, хохирогч хамгаалах зорилгоор олон улсын байгууллага /ОУБ/ гадаад улстай шууд мэдээлэл солилцох, хамтран ажиллах ажиллагааг явуулах, бүрдүүлэх, холбогч офицерыг ажиллуулах гэсэн ийм саналтай байна. Ингээд Монгол Улсад өртөж, гадаад улсад өртөж хохирсон нийт хохирогчид маань Зүүн Өмнөд Азийн улс орнуудад байна гэж тоон судалгаа дээрээс харагдаж байгаа. Тийм учраас энэ жишээн дээр дурдсан Зүүн Өмнөд Азийн Emergency Response Network буюу Шуурхай мэдээлэл, хохирогч аврах хамтарсан ажиллагаа гэсэн 3 тулгуурт суурилсан энэ орчин үеийн хурдан үйлдлийн олон улсын энэ механизмыг Зүүн Өмнөд Азийн орнууд хоорондоо хэрэгжүүлэн ажилладаг юм байна. Тэгэхээр цагдаагийн байгууллагаас энэ ХХГХ-тэй тэмцэх энэ Зүүн өмнөд Азид хохирч байгаа хохирогчийг хамгаалах чиглэлээр энэ тухайн байгууллагатай ажиллах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, тухайн бүс нутаг дээр холбогч офицер ажиллуулах гэсэн ийм санал гаргаж байна.

2 дугаарт олон улсын туршлагад ХХГХ-ийн хохирлыг нөхөн төлөх, нийгэмшүүлэх зардлыг санхүүжүүлэх асуудлыг дан ганц төр даадаггүй. ОУБ тусгай сан буруутай этгээдийг хөрөнгө хураалт гэсэн хосолсон загвараар шийддэг. Иймд ХХГХ-ийн хохирлын тусгай дэд сан байгуулах, гэмт этгээдийн ашиг орлогыг хурааж, хохирогчид төлбөр олгох механизмыг сайжруулах. ХХГХ-ийн хохирогчдыг нийгэмд дахин нэгтгэх, мэргэжлийн сургалт, ажлын байраар хангах урт хугацааны хөтөлбөр хэрэгжүүлэх. Хохирогч төвтэй нэгдсэн үйлчилгээний төв байгуулах.

4 дүгээрт, Монгол Улсад ХЗДХ-ийн сайдын 2017 оны А49 хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх хяналт тавих журамд хяналт тавин ажиллаж байгаа. Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, алба хаагчдын ажлын ачааллыг

бууруулах зорилгоор ХУМТРА санд энэ ИМонголиа платформыг оруулж иргэдээс Монгол Улсын хилээр нэвтрүүлэх энэ хүсэлтийг иргэдээс цахимаар авдаг хэлбэр лүү шилжүүлэх ийм саналтай. Сүүлийн жилүүдэд Монгол Улс руу чиглэсэн аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаатай холбоотой гадаадын иргэдээс Монгол Улсад тайчих үзүүлбэртэй баар, караокены чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, бусдыг биеэ үнэлэхийг зохион байгуулдаг, хүн худалдаалах гэмт хэргүүд бүртгэгдэж эхэлсэн.

Мөн хар тамхи, мансууруулах бодис, мөрийтэй тоглоом зэрэг бусад төрлийн гэмт хэрэгтэй хавсран үйлдэгдэж байгаа нь цаашид энэ ЭЦА-ны нэгж дээр байж байгаа энэ ХХГХ-тэй тэмцэх тасгийн алба хаагч нарыг чадавхжуулах, бүтэц, орон тоог бэхжүүлэх гэсэн саналтай байна. Танилцуулж дууслаа.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Ганчулуун даргад. Хууль зүйн сайд ирсэн байна, хуралд оролцож байна. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцсон хүмүүсийг би түрүүн танилцуулсан байгаа. Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Батнайрамдал гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

**П.Сайнзориг:** Ерөнхий ХХГХ-тэй тэмцэх ажлын талаас сонслоо гэж ойлголоо. Тэгэхээр би нэг хүсэлт байгаа. Байнгын хорооны даргаа 1 дүгээрт яах вэ Гэр бүлийн хууль, Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэлэлцэж байгаа. Энэтэй холбоотой хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн эсрэг зөрчлийн талаарх гэмт хэрэг зөрчилтэй тэмцэж байгаа ЗГ, ХЗДХЯ, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сонсьё гэж бодож байна. Яагаад би энийг хэлээд байна гэхээр хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил хийвэл эцэг, эх байх эрхийг нь хасах энэ тэр гээд нэлээн ноцтой үр дагавартай зүйлүүд ингээд зохицуулалтууд орж ирээд байгаа, жоохон өргөн хүрээнд байгаа. Тэгэхээр энэний нөхцөл байдлыг бид хэд бас нэг ХЗБХ энэ хуулиудын хэлэлцүүлэг эхлэхээс өмнө сонсьё гэж бодож байна. 1 дүгээрт энэ хүсэлтийг хэлэх гэсэн юм. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэж байгаа ажлын явцыг нэг сонсьё, энийг ХЗДХ-ийн сайд зохион байгуулж өгөөч гэж 1 дүгээрт хүсэлт байна.

2 дугаарт энэ ХХГХ-тэй холбоотой та хэд бас янз бүрийн эх сурвалжуудыг ашиглаж байгаа, гүйцэтгэх ажлын шугамаар мэдээллүүдийг харж байгаа л гээд байдаг. Би зүгээр нэг сэтгэл эмзэглүүлээд байгаа нэг зүйл байна. АНУ-ын Төрийн департаментын веб сайт дээр манайтай холбоотой манай зарим улс төрчдийн нэр гарч ирээд байгаа. Тэн дээр ингээд Монгол охидтой цагийг өнгөрөөх энэ тэр ингээд ийм бичвэрүүд ингээд явагдаад байгаа байхгүй юу. Энийг шалгаж үзсэн юм байгаа юу Ганчулуун даргаа? Яг үнэндээ хэлэхэд бусад улс орнууд чинь яг энэ мэдээллийн сайтуудыг нягтлаад, өөр өөрийн шугамаараа юмнуудыг мухарлаад, олон нийтдээ эргэлзээ төрүүлэхгүйгээр ингээд цэгцлээд байх шиг байна.

Тэгээд бид хэд болохоор ингээд ийм ноцтой зүйл, бусад АНУ-ын төрийн эрх бүхий байгууллагын веб сайт дээр нэр гарч ирээд байхад бид ингээд анзаардаггүй. Тэн дээр чинь бараг ингээд Монгол охид авч очиж байна, Монгол охины виз гараагүй байна шүү. Монгол охидтой цагийг өнгөрөөх энэ тэр гээд юмнууд ингээд яригдаад байна лээ шүү дээ. Тэгэхээр энийг манай цагдаагийн байгууллага анзаардаг юм болов уу, эсвэл яадаг юм бол?

Ер нь Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон Цагдаагийн албаны тухай хуулиар энэ олон нийтийн сүлжээн дээр гарч байгаа ийм эх сурвалжийн мэдээллүүдийг шалгах үүрэгтэй шүү дээ цагдаагийн байгууллага. Энэ дээр юу хийж байна вэ? Би зүгээр энийг шалгах ёстой л гэж бодоод байгаа юм. Тэгээд энэ үйл ажиллагаагаар дамжаад манай уул уурхайн бодлого, эдийн засгийн нөхцөл байдал энэ тэр лүү бас нөлөөлдөг зүйлүүд байдаг юм байна гэж зүгээр харагдахаар байна лээ шүү дээ. Тэнд маш олон манай эдийн засгийн суурь мэдээллүүд дурдагдаад байна, зарим ордуудын нэр.

Ингээд янз бүрийн байдлаар энэ охид, хүүхдүүдийг зуучилж аваачиж өгдөг ийм үйл ажиллагаа байсан юм биш биз дээ гэж бодогдохоор. Энэ үйл ажиллагаагаараа дамжуулаад манай энэ улс төр, ялангуяа энэ уул уурхайтай холбоотой энэ төрийн эрх бүхий байгууллагуудын шийдвэр дээр, шийдвэрүүд гараад байсан юм биш биз дээ гэж бодогдохоор.../минут дуусав/

*Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар 11 цаг 10 минутаас хуралдааныг даргалав.*

**Б.Баярбаатар:** Сайнзориг гишүүнд 1 минут нэмж өгье.

**П.Сайнзориг:** Цаг хугацаа юмнуудыг харахаар тэр Дубайн гэрээ байгуулагдах үеийн нөхцөл байдлуудтай цаг хугацаа бас уялдаж харагдаад байгаа байхгүй юу. Тэгээд ийм зүйлүүдийг харагдах юм. Тэгээд би сонирхоод орж харж байгаа юм 941 илэрц илэрч байна лээ. Яг охид, хүүхнүүдийг зуучлах, аваачиж өгөх, виз гараагүй байна шүү энэ тэр гээд 3, 4 илэрц байна лээ. Энэ дээр яг ямар бодолтой байгаа вэ? Тэгээд ер нь зүгээр цаашдаа энийг нягтлаад мухарлах ёстой шүү. Ийм нүдгүй юм шиг, чихгүй юм шиг манай хууль хяналтын байгууллага сууж болохгүй байх. Энэ ямар нэгэн байдлаар олон нийтэд эргэлзээг төрүүлж байгаа гэж үзэж байгаа шүү. Тэгээд энэ Дубайн гэрээг байгуулах ч гэсэн ийм зүйлүүдэд цаана нь ард нь янз янзын шантааж шахалт ийм зүйлүүд байсан юм биш биз дээ. Ийм хардалтууд байх юм. Тэгээд энэ Дубай Оюу толгой /ОТ/ гараад ирэхээр л нэг хүн ч юм уу манай нам, бас Ардчилсан нам /АН/-ын нэг хүмүүс ингээд.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** 5 номер хариулъя, 4 номер хариулах юм уу? 4 номер.

**Э.Ганчулуун:** Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Цахим орчин сүүлийн үед явагдаж байгаа энэ мэдээлэлтэй холбоотойгоор цагдаагийн байгууллага дээр судалж байгаа, үзэж байгаа мэдээллүүд байгаа. Мөн таны сая хэлж байгаа тэр 949-ийн илэрц гарч байна гээд. Цагдаагийн байгууллагаас манай Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газраас энэ асуудалтай холбоотойгоор нэлээдгүй ажлууд, судалгаа юмнуудыг гаргаж ирсэн. Биднийхээс одоогийн байдлаар 1 мянга орчим илэрцүүд гарчихсан, энэ дээр судалгаа юмнууд хийгээд явж байгаа ажлууд байгаа. Энэ яг мэдээлэлтэй холбоотой таны сая асуусан асуулттай холбоотой мэдээллүүдийг би танд өөрт чинь дараа нь танилцуулгаар хүргүүлж, танилцуулъя гэж бодож байна.

**Б.Баярбаатар:** Сайнзориг гишүүн тодруулга 1 минут.

**П.Сайнзориг:** Надад яах вэ, би зүгээр олон нийтэд л яагаад байгаа юм. Манай ингээд хэвлэлийнхэн ч ингээд л эрэн сурвалжлах сэтгүүл зүйн асуудал, ийм ХХГХ-ийн тайлан яриад, ийм ноцтой юм яаж байхад одоо нэг ийм мөлгөр битгий

хариулт хэлээч. Шалгана бол шалгана. Тэгээд энд чинь Монгол Улсын Төрийн тэргүүнээр ажиллаж байсан Ерөнхийлөгч Элбэгдоржийн нэр, Сайханбилэгийн нэр, Пүрэвсүрэн гээд Гадаад хэргийн сайд байсан хүний нэр дурдагдаад байна шүү дээ. Тэгээд энэ яг ОТ болон уул уурхайн том, том ордууд тэр Хэнтийд байгаа нүүрсний орд, ер нь тэгээд энэ манай эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, сонгуулийн үйл явц бүх зүйлүүд чинь тэнд тайлагнагдаж байсан байна лээ шүү дээ тэр Эпштейн нөхөр дээр чинь. Тэгээд манай улс төрчдийг ингээд барьцаалчихдаг байсан юм биш биз дээ гэдэг хардалтууд байна шүү дээ. Тэгээд энэ ОТ Дубайн асуудал яриад ирэхээр л нам харгалзахгүй 2, 3 хүний нэр ингээд гараад ирдэг, байнгын хамгаалж ярьдаг Баярцогтоос эхлээд. Ерөөсөө энэ зээлийн хэлэлцээрийн хүүгийн асуудал болоод 10 жил тутам ярих юман дээр л үсэрч гарч ирдэг энэ бүх зүйлүүдийг хамгаалж ярьдаг олон.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Хариулт, хариултаа тодорхой өгөөрэй 1 дүгээрт. 2 дугаарт наадах чинь цахим орчинд явж байгаа мэдээ мэдээлэл биш шүү. АНУ-ын Хууль зүйн яамны албан веб сайт дээр тавигдсан мэдээ мэдээлэл байгаа гэдгийг зөв хараарай. 4 номер.

**Э.Ганчулуун:** Гишүүний асуултад нэмэлт хариулт хэлье. Цагдаагийн байгууллагаас энэ цахим орчинд гарч байгаа мэдээлэлтэй холбоотой шалгахгүй байгаа асуудал байхгүй. Шалгалтын ажлууд юмнууд хийгдээд явж байгаа. Хамгийн гол нь Америк улстай Монгол Улс эрх зүйн харилцан туслалцаа байхгүй, албан бус шугамаар тодорхой хэмжээний мэдээллүүдээ солилцоод явж байгаа. Тийм болохоор би танд дараа нь тусад нь танилцуулъя гэж хэлээд байгаа нь ийм учиртай юм. Тэрнээс цагдаагийн байгууллага цахим орчинд гарч байгаа гэмт хэргийн шинжтэй мэдээ мэдээлэл дээр гадаад улс орон гэхгүй, ер нь энэ дээр гарч байгаа бүх л мэдээлэл дээр шалгалтын ажлуудыг хийж, гэмт хэрэгт шинжтэй эсэх дээр нь бүгдийг нь шалгаад явж байгаа шүү гэдгийг хэлье.

**Б.Баярбаатар:** Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

**Да.Цогтбаатар:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Цагдаагийн байгууллага ямар ч байсан 6 ч гэнэ үү, 9 ч гэнэ үү хүний бүрэлдэхүүнтэй ажиллаад, энэ цахим орчинд хүний эд, эрхтэн, хүн наймаалах, насанд хүрээгүй хүүхдүүдийг бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх чиглэлд ажиллаад байгаа юм байна, талархал илэрхийлье. Тэгээд миний асуулт давхацчихлаа, энэ Сайнзориг гишүүнтэй.

Жеффри Эпштейн /Jeffrey Edward Epstein/ гэдэг нэртэй холбоотой, тэр бол 2013-аас 14 оны дататай факт болоод үлдчихсэн байгаа. Тэгээд мэдээлэл нь ил тод зарлагдчихсан байгаа. Энэ мэдээллийн талаар энэ цагдаагийн байгууллагаас хийж, хэрэгжүүлж байсан ажил байна уу? Энэ чинь зөвхөн энгийн нэг иргэн бол биш, энэ чинь бүүр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл /ҮАБЗ/-ийн даргын асуудал, 2, 3 нэрээрээ Гадаад харилцааны сайд, тэгээд сая энэ уул уурхайн томоохон ордууд бүүр нэр устайгаа ОТ гэдэг юм уу, Эрдэнэт гэдэг юм яригдчихсан. Дээрээс нь та бүгдийн сая энд танилцуулсан энэ насанд хүрээгүй хүүхдийг хүний наймааны хэрэгсэл болгох, бэлгийн мөлжлөгт оруулах гэдэг дээр асуудлууд яригдчихсан. Та хэд бол сая танилцуулгад нэг ойр орчмын Зүүн Азийн орнууд ч юм уу, нэг ойр орчмынхоо орнуудыг л яриад байх шиг байна. Гэтэл энэ чинь бүүр дэлхий тойроод явчихсан асуудал үүсээд байна.

Тэгээд та бол миний ойлгосноор сая энэ цагдаагийн байгууллагын дэд дарга юм байна гэж ойлгосон. Тэгээд сүүлд аз болоход энэ Хууль зүйн сайд ороод ирлээ. Тэгэхээр энэ дээр хамтраад нэлээн ажлуудыг ажлуудыг хийхгүй бол, яах вэ хариултаас ч гэсэн анзаараад байхад ил ярьж болдог юм байна, болдоггүй юм байна. Тэгээд ил ярьж болохгүй байгаа, одоо юу гэдэг юм дараа дараагийнхаа гэмт хэргийг бэлдэж байгаа улсуудад мэдээллийг нь ил өгчих гээд байгаа бол бичгээр нэг тодорхой мэдээллүүдээ ирүүлэхгүй бол энэ дээр ямар ч Монгол хүн эмзэглэхээр асуудлууд яригдаад байгаа шүү гэдгийг маш сайн ойлгохгүй бол хүүхдүүд мөчлөгдчихсөн асуудал шүүхээр шийдэгдэж чадахгүй байна, хүүхэд алга болчихсон асуудал олдохгүй байгаад хэвээрээ байгаад байна. Эдгээр дээр яг ингээд бид ажиллаж чадаж байна шүү гэдгээ тодорхой хэмжээнд харуулж, мэдээллийг нь ирүүлж, бид тэрийг нь ярих хүрээнд нь эвтэйхэн шиг зөв ойлголтыг нь өгөхгүй бол нийгэмд тэр чигээрээ хүүхэд олддоггүй, хүүхэд мөчлөгддөг, бүүр энэ чинь тив дэлхий алгасаад Америкт очоод хүүхэд гэмт хэргийн золиос болоод байж болохгүй шүү гэдгийг бас анхааруулж хэлье. Хариулт нь сая авчихсан учраас ойлгомжтой байх гэж бодож байна. Тэгээд цаасаар мэдээлэл ирүүлэх байх гэж бодож байна.

**Б.Баярбаатар:** Санал хэллээ. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

**С.Одонтуяа:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр энэ ХХГХ-ийн асуудал нэг үеэ бодвол энэ олон нийтийн ойлголт, манай энэ шийдвэр гаргах түвшний хүмүүсийн ч гэсэн ойлголт нэлээн өөр түвшинд хүрсэн байна. Энэ чинь ийм гэмт хэрэг юм байна, энэнтэй тэмцэх ёстой юм байна, хохирогчид байдаг юм байна гэдэг ийм зүйл гарч байна. Өмнө нь би санаж байна 2008 онд энэ ХХГХ-ийн хохирогч 2 эмэгтэй гараад ирээд хөөрхий хэвлэлд ярилцлага өгсөн чинь зүгээр ерөөсөө хүмүүс чинь муу биеэ үнэлэгчид хохь чинь, зайлбал таарна гэсэн ийм зүйл маш их явж байсан юм. Тэгээд энэ өөрөө их далд хэлбэрт орчихдог. Тэгэхээр сүүлийн үед ер нь энэ хүмүүсийн бодол санаа энэ бол өөр болсонд талархалтай байна.

Надтай нөгөө Шаарийбуу гуай уулзаж байсан. Малайз руу их олон удаа явдаг үнэхээр аймшигтай дүр зураг байдаг юм гээд хэлж байна лээ. Тэнд ерөөсөө зүгээр шорон шиг юманд байлгадаг, зарим нь энэ нэг торон дотор, зарим нь бүүр гав гинжтэй байдаг юм байна лээ, ёстой аймшигтай гээд л бүүр яаж байсан, энэ дээр заавал ажиллах ёстой гээд. Тэгэхээр би зүгээр нэг ийм ийм зүйл хийвэл хэр хийх гэдгийг, би сошиалаар нэлээн юм хардаг хэр нь хараагүй. Энэ ЦЕГ сүүлийн үед нэг хэд хэдэн аянууд хийж байна шүү дээ. Энэ хар тамхины эсрэг, үе тэнгийн дээрэлхэлт, энэ шиг энэ хүн худалдаалахын эсрэг энэ ойлголтыг нэлээн өгмөөр байгаа юм. Тэр хүнийх нь царайг гаргахгүйгээр энэ кейсүүдийг яриулах ёстой, очоод ямар нөхцөлд байсан юм, яаж зовсон, тамлуулсан энэ бүх зүйлийг ярьж ингэвэл явах гэж байгаа хүмүүсийг зогсоож чадна.

Тэгэхгүй та нарын энэ судалгааг харахад маш их олон хүн явдаг юм байна шүү дээ энэ гадагшаагаа энэ чиглэлээр. Тэгэхээр энэ чинь бүгд гэмт хэргийн золиос болно л гэсэн үг. Тэгэхээр энэ аянуудыг хийж байж аль болохоор энэ асуудлыг гаргахгүй байх талаар урьдчилан сэргийлэхгүй бол юугаа ч мэдэхгүй нэг жоохон охид явдаг, очоод том цалин ихтэй ажилд орно гээд бодчихдог. Тийм учраас энэ бол маш аюултай зүйл байгаа. Тэгэхээр энийг бид хүүхэд дээр гайгүй байх гээд хаяж болохгүй. Эпштейний файлууд чинь аймшгийн бүр үзэхийн аргагүй тийм видеонууд гарч байна шүү дээ хүүхдийг бүүр яаж тамлан зовоож байгаа. Энэ дээр манай улс маш сайн анхаарах ёстой.

Нэг асуулт байна. Энэ хийх ажил дээр холбогч офицер ажиллуулна гэчихсэн байгаа. Энэ хүн яг хэдэн хүний тухай яриад байгаа юм бэ, Монголд юм уу? Би хуучин ТЕГ-ынхан ХХГХ, хар тамхи хоёр байдаг юм. Бидний орон тоо хүрэхгүй байна гэхээр орон тоог нь нэмүүлж өгсөн юм. Тэгэхээр одоо яг энэ ямар хүмүүсийн тухай яриад байгаа юм бэ, Элчин сайдын яам /ЭСЯ/-дуудын тэр хүмүүс чинь бас энэ дээр хэр холбоотой ажилладаг юм бэ? Энэ асуудлаа нэг дэлгэрүүлээд сайн тайлбарлачихвал бид энийг шийдэх боломжтой, шийдье. Энэ хэдэн хүний тухай яриад.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** 5 номер Дашзэвэг дэд хурандаа хариулъя.

**Ц.Дашзэвэг:** Таны асуултад хариулъя. Миний энэ яриад байгаа санал бол энэ холбогч офицер гэдэг нь тухайн бүс нутгийн улс орнуудтай мэдээлэл солилцох, хамтран тухайн хохирогчийг аюулгүй хамгаалалтад авах, хохирогчийг эх оронд нь буцаан шилжүүлэх гэдэг юм уу ийм чиглэлээр хамтран ажиллах чиглэлээр холбогч офицер ажиллуулна. Энэ ажиллуулах хэлбэр нь болохоор тухайн улс оронд заавал энэ холбогч офицерыг ингэж ажиллуулах биш, эндээ ажиллаж байгаа албан хаагч нараасаа албан хаагчдаа томилоод, тухайн Зүүн Азийн бүс орнуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулах хууль, эрх зүйн орчнуудыг бүрдүүлснээр бид мэдээллээ солилцох ийм сувгийг бүрдүүлнэ гэсэн ийм ойлголтоор би ийм санал тавьсан байгаа. Баярлалаа.

**Б.Баярбаатар:** Одонтуяа гишүүн тодруулъя.

**С.Одонтуяа:** Тэгэхээр та хэд саналаа оруулаад ирэх үү, яг ямар санамж бичиг байгуулмаар байгаа юм бэ? Бид энэ Азийн орнуудаар явж байхад энэ хар тамхины эсрэг юунуудтай нэлээдгүй зүйлүүд байгаа. Тэгэхээр яг энэ хүн худалдаалахтай холбоо яг ямар орнуудтай нь хамтын ажиллагаа байгаа юм ямар конвенцын дагуу, яг ямар орнуудтай ажиллахад ийм зүйл чинь хэрэгтэй байгаа юм бэ? Хууль, эрх зүйн орчиндоо оруулах юм уу, дүрэм журамд юм уу, эсвэл төсөв санхүү юм уу гэдгээ нэг бидэнд бэлдээд өгөх үү? Тэгвэл бид энэ асуудлыг аль болохоор шийдэх талаар нь ажиллая. Яг тодорхой.

**Б.Баярбаатар:** Хууль зүй, дотоод хэргийн сайд Амарсайхан сайд нэмж хариулъя.

**С.Амарсайхан:** Энэ хүний наймаатай холбоотой, хар тамхи, цахим гэмт хэрэгтэй холбоотой нөхцөл байдлын талаар товчхон мэдээллийг та бүхэн холбогдох байгууллагуудаас сонсож байна. Энэ нэлээн анхаарал татсан асуудал болж байгаа юм. Хүний наймаа гэдэг зөвхөн хүн наймаалах гэхээс илүүтэй хөдөлмөр эрхлэлт, тэр дундаа албадан хөдөлмөрлөлт, цаашилбал нөгөө үеийн дээрэлхэлт гэдэгтэй адилхан үеийн янз янзын үе тэнгийнхний мөлжлөг гэдэг ийм хэлбэр лүү орж байгаа. Цахим гэмт хэрэг өсөж байгаа. Гэхдээ арга сэдэл нь улам нарийссан ийм нөхцөл байдал руу орж байгаа. Манай нөхцөлд ч байна, гадаад улс орнуудын хэмжээнд ч байна. Юнодкийн /UNODC/ судалгаагаар 156 улсын нөхцөл байдалд үнэлсэн, үндэслэсэн судалгаанууд гарсан байгаа. Энэ өөрөө сая хэлснээр илүү нарийн ийм.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Гүйцээгээд хариулчих Амарсайхан сайд.

**С.Амарсайхан:** Зохион байгуулалттай гэмт хэрэг хэлбэр лүүгээ орж байгаа. Өөрөөр хэлбэл цахим орчинд их үйлдэгдэж байна. Манай улсын хувьд гэвэл БНСУ, Турк улс, БНХАУ гэсэн улс орнуудад энэ хүний наймаа, хөдөлмөрийн мөлжлөг, албадан хөдөлмөрлөх хэлбэрээр хүний наймаа олон төрлөөр дүрсээ хувиргаж хэрэгжиж байна гэсэн ийм тооцоо бий. 24 оны байдлаар 27,6 сая хүн албадан хөдөлмөрт хүний наймаанд өртсөн байна гэж байгаа юм. 50 сая хүн үе тэнгийнхний мөлжлөг гэж ярьдаг энд өртсөн байна гэж байгаа юм. Нийтдээ энэ хэрэг өөрөө дэлхийн хэмжээнд 236 тэрбум ам.долларын хэмжээний эргэлттэй бизнес болж хувирсан байгаа юм. Манай улсад энэ чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд тодорхой үр дүнгээ өгч байгаа ч гэсэн энэ цагдаагийн байгууллага энэ гэмт хэрэгтэй тэмцэж байгаа ч гэсэн энэ.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуулт асууя.

**О.Алтангэрэл:** Би тодорхой асуулт асууя, тодорхой хариулаарай. Энэ хүний, хүн худалдаалах гэмт хэргийн асуудал яг үнэн л дээ 8, 9 оны үеэс нэлээн идэвхтэй яригдаж эхэлсэн юм. Тэгээд 2010 оны үед эхний том шүүх хурлууд болоод, би өөрөө өмгөөлөгчөөр тэр шүүх хуралд оролцоод явж байсан ийм хүн байгаа юм. Тэгээд энэ үеэс хойш одоо ингээд олон жил ажиглаад байхад хүний наймааны асуудалд бид ач холбогдол өгдөг, олон улсын зээл, тусламж бас авдаг. Тэгэхдээ бид энэ гэмт хэргийн бүрэлдэхүүн талаасаа биеэ үнэлэлтийг зохион байгуулах болон хүний наймаа гэдэг 2 чинь их өөр зүйлүүд шүү дээ. Эрүүгийн хуульд ч өөрөөр тусгасан, олон улсын гэрээ конвенц нь ч өөр. Нэг нь хэн нэгний биеийг сайн дураар хэн нэгэн сайн дураар биеэ үнэлээд, гуравдагч этгээд ашиг олдог бол нөгөөдөх нь айлган сүрдүүлж, албадлагаар, хүчээр ингэж хууран мэхэлж явдаг.

Тэгэхээр түрүүн эхний танилцуулга дээр чинь энэ нөгөө караокед биеэ үнэлэлттэй холбоотой зүйлүүд яригдаж байна лээ. Та хэд маань гэмт хэргийн талаас нь яг энэ хүний наймаа болон биеэ үнэлэлтийг зохион байгуулах гэдгийг яаж ангилж авч үзэж байгаа вэ? Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэж байгаа нэгжийн хувьд энэ асуудлыг зэрэг шалгаж байгаа юу, үгүй юү? Яаж ангилж байгаа вэ гэсэн эхний нэг асуулт?

2 дахь асуулт энэ хүний наймаа зөвхөн хүний биеийг үнэлүүлээд байдаг юм биш. Хуурч мэхэлж аваачаад зөвхөн биеийг нь үнэлэх зорилгоор биеэ үнэлэгчдийг аваад явдаг юм биш. Монгол залуучуудыг авч явж, Монгол хэлтэй энэ байдлыг нь ашиглаж телеграм залилан, цахим залиланд ингэж ажиллуулах ийм явдал ер нь гарч байна гэсэн мэдээлэл байгаа. Тэгэхээр энэ чиглэлийн мэдээлэл юу байна вэ? Зөвхөн биеэ үнэлэлтээс гадна, хууран мэхэлж, хүчээр ингэж цахим залилангийн үйл ажиллагааны зохион байгуулагч хэлбэрээр оруулж байгаа үйлдэл юу байна вэ? Үүнтэй цагдаагийн байгууллага ямар арга хэлбэрээр тэмцэж байна вэ, нөхцөл байдал нь ямар байна вэ, цаашдаа ямар арга хэмжээ авах төлөвлөгөө байна гэдэг ийм асуулт?

**Б.Баярбаатар:** Их тодорхой асуулаа. Хэн хариулах юм бэ? Дашзэвэг дэд хурандаа 5 номер.

**Ц.Дашзэвэг:** Таны асуултад хариулъя. Монгол Улсын Эрүүгийн хуульд ХХГХ, бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэх, зохион байгуулах гэдэг юм уу ингээд тус тусад нь ингээд зүйл ангиудаар заагаад өгчихсөн байж байгаа. Сая миний дурдсан мэдээлэл дээр бол яг энэ нөгөө ХХГХ-ийн болон биеэ үнэлэх, зохион байгуулах, бэлгийн

мөлжлөгтэй холбоотой ийм нөхцөл байдлыг бол товчхон дурдсан байж байгаа. ХХГХ бол мэдээж бусдыг эрхшээлдээ оруулах, эмзэг байдлаар нь мэдээллийг эрхшээлдээ оруулах, өрийн барьцаанд оруулах, зорчих эрхийг нь хязгаарлах гэдэг байдлаар хүчээр бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглаж байгаа энэ үйлдлүүд бол хүн худалдаалах гэдэг ийм зүйл анги руугаа орно. Биеэ үнэлэх, зохион байгуулах гэдэг тодорхой байрлал, цэг газруудад биеэ үнэлэх, түүнээсээ ашиг орлого олох гэсэн ийм 2 өөр ийм ойлголтоор ингэж явж байгаа. Таны ярьдаг зөв. Би тэгэхдээ энэ дээр урьдын асуудал дээр тодорхой дэлгэрэнгүй ярьсангүй.

Цагдаагийн байгууллагаас бол биеэ үнэлэх, зохион байгуулах энэ саун массаж, тайчих үзүүлбэртэй шөнийн цэнгээний газрууд гээд байгаа энэ ажиллаж байгаа энэ газрууд нь яг нөгөө нэг нийгмийн эмзэг бүлэг, гэр орноосоо дайжсан энэ насанд хүрээгүй охдыг элсүүлдэг, нэг сайн ах, эгч болдог, ингээд тухайн газартаа орогнуулдаг, хоол хүнсээр хангадаг ийм хэлбэр ингэж байж байгаа нь нөгөө талаараа нөгөө ХХГХ-ийн хохирогч болох нөгөө эрсдэлийг ингээд бүрдүүлж байгаа ийм нөхцөл байдал байна гэдэг үүднээс ярьсан ийм тайлбар.

**Б.Баярбаатар:** 4 номер Ганчулуун хурандаа нэмээд хариулчих.

**Э.Ганчулуун:** Гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Мөн сая гишүүн бас хэллээ. Биеэ, хүн худалдаалах гэдэг нь дан ганц гадаад улс руу аваачаад биеийг нь үнэлэгдээд байгаа асуудал биш шүү, энэ тал дээр бас анзаарч харж байна уу гээд, энэ яг зөв асуудал л даа. Энэ яахаар энэ сүүлийн үед цахим орчинд өндөр цалинтай ажилд зуучилна гэдэг зарын дагуу маш олон Монгол Улсын иргэд энэ мэдээллийн дагуу ингэж гадаад улс руу очдог. Тухайн гадаад улсад очсоныхоо дараа яадаг вэ гэхээр хүчээр хөдөлмөр эрхлүүлдэг. Саяын мэдээлэл хийж байхад бид бүхэн та бүхэнд сая танилцуулсан тэр Мьянмар улсад болохоор БНХАУ-ын маф-н санхүүжилтээр КК парк гэж энэ цогцолбор дээр яг энэ асуудал болсон. Монгол Улсын 12 иргэнийг өндөр цалинтай ажилд зуучилна, зуучилж ингэж аваачиж хүчээр хөдөлмөр хийлгэсэн. Энэ нь ямар хөтөлбөр байсан гэхээр цахим орчинд телеграм залилан гэдэг энэ ажил дээр ажиллуулаад.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Гүйцээгээд хариулчих 4 номер.

**Э.Ганчулуун:** Энэ дээр нийтдээ Монгол Улсад телеграм залилангаар 2,1 тэрбум төгрөгийн хохирол учруулсан ийм гэмт хэрэг үйлдэгдэж байсныг эндээс тухайн улстай мэдээлэл солилцож, тухайн гэмт хэргийг таслан зогсоож, Монгол Улсын иргэдийг Монгол Улсад ирэхэд нь бас баривчилсан байгаа. Тэгэхээр та бүхэн нэг ойлголт гарч ирэх байх. Яагаад хохирогч гэхээд Монгол Улсад ирэхэд нь нөгөө иргэнээ баривчилсан бэ гээд. Тухайн иргэд маань очиж ажиллаж байхдаа тухайн бүлэгт сайн дураараа элссэн 12 иргэн байсан. Тухайн бүлэгтэй хамтарч ажиллаж байсан. Тэгээд Монгол Улсад ирээд Монгол Улсаас иргэдээ дахин бас эндээс хуурч мэхэлж авч явах ийм ажил зохион байгуулж байсныг цагдаагийн байгууллагаас илрүүлээд, таслан зогсоосон байгаа.

**Б.Баярбаатар:** Алтангэрэл гишүүн тодруулга 1 минут.

**О.Алтангэрэл:** Хариултыг ойлголоо. Тэгээд нэг зүйлийг яг хичээнгүйлж захиж хэлэхэд энэ ХХГХ-ийг анх яригдаж, олон нийт ойлголттой болж байх үед сурталчилгаа, олон нийтийн ажил их сайн явж байсан юм. Тэгээд их олноороо гадагшаа гарч байсан, хууртаж биеэ үнэлж байсан энэ урсгал нэг хэсэг зогсож

байсан. Одоо зөвхөн энэ хүн худалдаалахыг биеэ үнэлэхтэй холболгүйгээр, ийм гадагшаагаа цахим залилангийн хохирогч болов уу гэдэг талаас нь энэ олон нийтэд мэдээлэл, сурталчилгааныхаа ажлыг идэвхжүүлэх шаардлагатай байна шүү. Ингэвэл 1 дүгээрт, энэ ХХГХ-ийн золиос болох энэ хүмүүс маань урьдчилан сэргийлэгдэнэ. 2 дугаарт, гаднаас Монгол хүмүүс суучихаад телеграм болон бусад төрлийн аппликэйшн ашиглаад биднийг хуурч мэхлээд байдаг юм байна шүү гэсэн олон нийтийн ойлголт энэ цахим залиланд хууртах энэ эрсдэл нь бас багасах байх гэж бодож байна. Ийм учраас энэ урьдчилан сэргийлэх чиглэлдээ энэ зүйлээ бас анхаараарай гэж захиж хэлье. Үг хэллээ.

**Б.Баярбаатар:** Үг хэллээ. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

**Д.Ганбат:** Би больчихъё доо.

**Б.Баярбаатар:** Нэрээ татаж байна. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууна.

**Х.Булгантуяа:** Энэ тоон мэдээллүүдийг харахад сүүлийн 5, 6 жилийн дотор 92 хохирогч, түүнээс 54 нь насанд хүрээгүй хүүхэд байна гэдэг аймаар тоо. Сүүлийн 5, 6 жилийн дотор 21, 22, ингээд 23 он бол яг үнэнийг хэлэхэд хил төдийлөн сайн нээгдээгүй, гадаадын улс оронд зорчих байдал харьцангуй хязгаарлагдмал байхад ийм өндөр тоо гарч байгаа юм чинь дараагийн хэдэн жилд цахимтай нийлж байгаад энэ бүүр том тоо гарч магадгүй харагдаж байна. Тэгэхээр би та бүгдийг энэ ажлаа эрчимжүүлээсэй гэж бодож байна.

Сүүлийн хэдэн жилд Америкт Харви Вайнштейн /Harvey Weinstein/ гээд Америкийн film продюсер Холливудын одуудыг биеийг нь үнэлүүлж байсан талаар маш том хэрэг болсон, та бүхэн мэдэж байгаа. Puff daddy одоо үүнээсээ үүдээд бас шоронд байгаа. Ингээд Эпштейний файл гэнэ. Эпштейний файлын хамгийн санаа зовоож байгаа зүйл нь энэ бол зүгээр нэг урлаг соёлын од дунд биш, улс орон дамжаад, улс төр лүү ороод, улс төрчдийг биеэ үнэлэгч нараар дамжуулаад, дээрээс нь нэмээд хүний наймаа, ХХГХ-ээр дамжуулаад, дээрээс нь нэмээд олон улсын хуулийн байгууллагууд би бас үүн дээр Хууль зүйн сайдыг онцгойлон анхаараасай гэж бодож байгаа юм. Одоо зарим улс орнуудын хууль хяналтын байгууллагууд нь шалгаж байгаа зүйлүүд нь манай улс орны үзгийнх нь үзүүрээр том асуудал шийдэгддэг ийм албан тушаалтан хүмүүсийг янз янзын эвгүй байдалд оруулж байгаад бичлэг, дүрс бичлэгийг нь авч байгаад, үүгээр нь дамжуулж дарамталж байгаад янз янзын шийдвэр гаргуулчихсан юм биш биз дээ гэдгийг нь шалгаад байгаа юм байна.

Тэгэхээр энэ зөвхөн хүн наймаалах, ХХГХ-ээс бүүр давсан том асуудал болчихоод байгаа юм. Тэгэхээр манай энэ 3 сая орчим хуудас файл дотор ингээд хайгаад аваад үзэхээр АНУ-ын Хууль зүйн сайт дээр нь, яамных нь сайт дээр тавьсан юун дотор 900 гаруй нь Монгол Улстай холбоотой. Үүн дотор ахиад Монголын байгалийн баялагтай, сонгуультай, сонгуулийн тухай чинь ерөөсөө цаг, минутгүй илтгэж байсан. Дээрээс нь нэмээд хоорондоо үнэтэй үнэт эдлэл, зураг бэлэглэх, наймаалах асуудлыг ярьж байсан. Энд тэнд очиж уулзалт зохион байгуулна гэж байсан, уулзсан, уулзалт дээр юу болсныг бид мэдэшгүй. Тэгэхээр ийм зүйлүүд явагдаж байгаа учраас би үүний араас жишээлбэл байгуулагдсан Дубайн гэрээнд дээр ийм нөхцөл байдал үүссэн юм биш биз дээ? Монгол Улсад ийм ашиггүй гэрээ байгуулсан нь магадгүй энэ хүмүүсийг ийм хүнд байдалд оруулж

байгаад янз янзын бичлэг ч байдаг юм уу хийж байгаад ийм юм болсон юм биш биз дээ гэдэг дээр хууль хяналтын байгууллага шалгаж байгаа юу?

Олон нийтийн зүгээс дээрээс нь нэмээд 1, 2 хүүхдийн асуудлыг ингэж эмэгтэйчүүдийг аваачих гэж байгаа асуудлаар хоорондоо мессеж, мэйл бичсэн байна. Үүнээс олон ч байж магадгүй байна. Энэ хүмүүсийг дэлхийн улс орнуудад Америкт энэ тэр яаж байна вэ гэхээр бид гэрчийн хамгаалалтад авна, та бүхэн маань ил.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** 4 номер Ганчулуун хурандаа хариулъя.

**Э.Ганчулуун:** Гишүүний асуултад хариулъя. Танаас эхэлж асуусан тэр 5-аас 6 жил энэ гэмт хэргийн гаралт ийм байна гээд. Тухайн үед нөгөө нэг ковидтой холбоотой байх үед яг энэ цахим гэмт хэрэг ерөнхийдөө маш эрчимтэй өссөн гэмт хэргийн статистик мэдээгээр харахаар. Дээрэм хулгай гэдэг юм уу, бусад төрлийн гудамж талбайд үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчил нь буураад, яг цахим орчинд үйлдэгдэх гэмт хэрэг мөрийтэй тоглоом гэдэг юм уу, энэ төрлийн залилах гэмт хэргүүд нь өссөн ийм нөхцөл байдалтай байдаг.

Таны сая асуугаад байгаа тэр Америкийн нэгдсэн улсын энэ сүүлийн үеийн цахим орчинд гарч байгаа энэ асуудлыг цагдаагийн байгууллагаас шалгаагүй биш, шалгаж судалж байгаа мэдээллүүд байгаа. Энэ дээр хийгдэж байгаа ажлууд бас байгаа. Мэдээж энэ тухайн асуудлууд нь яг бодитой үнэн эсэх асуудал дээр нотломжийн юмнуудыг бүрдүүлэх ийм юмнууд нь мэдээж би бас түрүүн хэлсэн АНУ-тай эрх зүйн харилцан туслалцаагүй болохоор бид шалгах ажилд маань тодорхой хэмжээний саад тотгор байна. Гэхдээ бид энэ дээр ингээд зогсчихгүй, яг бусад байдлаар албан бус харилцаагаар юмнуудаа мэдээллээ солилцуулаад хийгдэж байгаа ажлууд байгаа гэдгийг хэлье. Тэгээд мөн Сайнзориг гишүүнд энэ танилцуулгыг хүргүүлье гэсэнтэй адилхан бас танд шаардлагатай мэдээллүүдийг давхар ирүүлье гэж бодож, хүргүүлье гэж бодож байна.

**Б.Баярбаатар:** Хууль зүйн дотоод хэргийн сайд Амарсайхан сайд нэмээд хариулъя.

**С.Амарсайхан** Энэ хүний наймаа, хар тамхи, цахим гэмт хэрэгтэй холбоотой асуудлуудыг нэлээн өндөр зохион байгуулалтад оруулж ажиллана. Тусгай ажлын хэсгүүдийг байгуулна. Манайд нэг буруу хандлага гэдэг юм уу, ойлголт байгаа. Хар тамхийг яриад байвал бид хэрэглээг нь нэмээд байна гэсээр байгаад урьдчилан сэргийлэх ажлууд орхигдсон. Тэр хэрээрээ энэ хар тамхины хэрэглээ хэрээс хэтэрсэн, хар тахал болсон гэж хэлж болно. Ялангуяа өсвөр насны хүүхдүүдийн дунд. Тэгээд 1 дүгээрт, энэ чиглэлийн арга хэмжээ, энэ чиглэлээр ажиллаж байгаа бүлэг, бүрэлдэхүүнүүдийг өргөтгөж, тодорхой стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.

2 дугаарт, хүний наймаа гэдэг зүгээр нэг яриад өнгөрдөг асуудал биш учраас энэ олон хэлбэрээр явагдаж байгаа, далд хэлбэрээр явагдаж байгаа хүний наймаатай холбоотой асуудал дээр бас ажлын хэсэг байгуулж, ер нь.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Булгантуяа гишүүн тодруулчих, дараа нь хариулъя.

**Х.Булгантуяа:** Тэгэхээр Хууль зүйн сайдыг үүн дээр бүүр нэлээн ач холбогдол өгч ажиллаасай гэж хүсэж байна. Дэлхийн улс орнуудад юу болж байна гэсэн чинь Эпштейнтэй дотно харилцаатай байсан гээд Английн хунтайжийг хэрэм зэргээ хураалгасан, одоо цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа. Английн Лордын танхимын гишүүн нь, мөн АНУ-д сууж байсан Элчин сайд нь татагдаж, Лордын танхимаасаа огцорсон. Одоо аль, аль нь цагдаад шалгуулж байгаа юм. Норвегийн Ерөнхий сайд байсан хүн, Нобелийн шагналын хорооны дарга байсан хүн бас шалгагдаж байгаа. Ингээд Европын зөвлөлөөс бүх энэ дипломат эрх ямба бүгдийг нь бас ... Францын Соёлын сайд байсан хүн мөн мөнгө угаасан байж болзошгүйгээр шалгагдаж байгаа гээд дэлхий даяараа ерөөсөө энэ хүнтэй бараг уулзсан хүн болгоныг шалгаж, ямар нэгэн байдлаар хамгийн гол нь тэр хүмүүсийн үзгийн үзүүрээр, эсхүл нууц мэдээлэл задруулсан байх вий, эсхүл аль нэг том групп компанид байдаг юм уу, өөрийнхөө улс орны эрх ашгийн эсрэг.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Хэн хариулах вэ? Амарсайхан сайд хариулах уу? ХЗДХ Амарсайхан сайд.

**С.Амарсайхан:** Энэ олон улсад өрнөж байгаа үйл явдлууд, манай дотоодод болж байгаа асуудлууд яг энэ хүний наймаатай холбоотой зарим нэг тодруулах асуудлуудыг ард иргэдээс, мөн УИХ, холбогдох байгууллагуудаас ирүүлж байгаа хүний эрхийн байгууллагуудаас. Тийм учраас энэ асуудлыг нарийвчилж шалгаж тогтоох, үнэн мөнийг нь ялгах, яг манайд бодитоор хүн наймаалагдсан уу, тийм бол ямар хугацаанд, хэзээ, ямар нөхцөл байдалд үйлдэгдсэн юм, үүний үр дагавраар ямар хор уршиг бий болчихоод байгаа юм, энэ дээр ямар, ямар зохион байгуулалттай бүлэглэл, эсвэл сүлжээ байгаа юм гэдгийг тодорхой олж илрүүлэхтэй холбоотой асуудал дээр анхаарч, энэ холбогдох байгууллагууд хянах, шалгах ажиллагаагаа явуулна цаашаа.

**Б.Баярбаатар:** Булгантуяа гишүүн болчихсон тийм ээ? Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

**О.Батнайрамдал:** Сая Эпштейний файлыг цахим орчинд гарч байгаа мэдээлэл гэж яриад байна. Энийг хэд хэдэн удаа хэллээ шүү. Энэ ийм учиртай юм. 2025 оны 7 сард Америкийн парламентын доод танхимд Хянан шалгах түр хороо байгуулагдаад, Эпштейний файлууд дээр үүнээс үүдэлтэй хүүхэд, насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн мөлжлөг, дэлхийн санхүүгийн сүлжээ, мөнгө угаалтын тухай асуудлууд, улс орнуудын өндөр албан тушаалтнууд дотоод асуудалд оролцсон гэсэн ийм ноцтой асуудлаар Хянан шалгах түр хороо хуралдаад, 4 сарын дараа буюу 2025 оны 11 сард Эпштейний файлын ил тод байдлын тухай хууль гэж Америкт баталсан юм. Энэ хуулийн хэрэгжилтийн хүрээнд Эпштейний энэ бүх имэйл болон асуудлууд, зургууд бүгдийг нь олон нийтэд ингэж ил болгосон. Тэгэхээр энэ зүгээр нэг цахим орчинд гараад байгаа мэдээлэл биш. Маш ноцтой асуудал дэлхий даяар яваад байгаа байхгүй юу.

Энэ дотор Монголчууд бид бүгдээрээ ороод хайлт хийгээд үзэж болно. Энэ дотор Монгол Улсын хамгийн өндөр албан тушаал хашиж байсан үе үеийн Ерөнхийлөгчид Элбэгдорж, Баттулга, Сайханбилэг ийм хүмүүсийн нэр илэрцээр гарч ирж байгаа. Дөнгөж саяхан 3 сарын өмнө Австралийн Financial Review гээд сэтгүүл дээр бас нэг ноцтой мэдээлэл гарчээ. 2026 оны 2 сарын 10-ны өдрийн мэдээ. 2013 оны үед ОТ зогсонги байдалд орчихсон, хоёрхон, жил, 2 жилийн дараа Дубайн гэрээ хийгдэх яг энэ цаг мөчид Элбэгдорж Ерөнхийлөгч Эпштейнтэй

уулзсан. Мөн Австралийн Ерөнхий сайд асан Кевин Руд /Kevin Rudd/, Израилын Ерөнхий сайд асан Эвуд Барак /Ehud Barak/, Норвегийн Ерөнхий сайд асан Киел Бондевик /Kjell Bondevik/ нарын дэмжлэгтэйгээр Эпштейний холбоотой дэмжлэгтэйгээр буцаад энэ дээр ОТ-н асуудал нэлээн хөндөгдсөн талаар маш дэлгэрэнгүй мэдээллийг Австралийн Financial Review гуравхан сарын өмнө гаргасан байна.

Бид ОТ Дубайтай холбоотой асуудлыг дандаа гаднаас аваад байгаа байхгүй юу. Энэ Дубайн гэрээ УИХ хүчингүй болгож цуцалсан энэ ноцтой гэрээг тухайн үедээ Ерөнхий сайд Сайханбилэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /ЗГХЭГ/-ын дарга Баярцогт нарын үед энэ хийгдсэн. Энэ Эпштейнтэй холбоотой байжээ гэдгийг энэ Австралийн Financial Review судалгаагаараа гаргаад байна л даа. Та нар бүгдээрээ ороод уншаарай. Гуравхан сарын өмнө гарсан байна. Панамын paper гээд бөөн ноцтой мэдээлэл гарсан. Бас нөгөө алдарт Баярцогтын Швейцар өөрөө ч мэдээгүй байдаг Швейцарт дансны мэдээлэл гарсан. Эпштейний файл гарлаа, Дубайн гэрээтэй холбоотой ОТ-н асуудал гарч ирж байгаа юм. Нөгөө л Баярцогт бас л ЗГХЭГ-ын дарга байхдаа хийгдсэн Дубайн гэрээний асуудал.

Монголын энэ ноцтой асуудлыг бид дандаа нэг гадаадын мэдээлэл задрахаар олж авдаг. Тэгээд тэрийгээ нэг цахим орчинд тавьсан мэдээлэл гэж уншиж ерөөсөө болохгүй юм. Энэний үр дагавар буцаад Монголын эдийн засаг болон Монголд хэдэн их наяд төгрөг, хэдэн тэрбум долларын.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** 1 минут Батнайрамдал гишүүнд нэмж өгье.

**О.Батнайрамдал:** Буцаад үр дагавар нь Монголын эдийн засаг, тэр битгий хэл бидний үр хүүхдийн ирээдүйгээр тэр чигээр нь тоглосон ийм үр дүн харагдаж байгаа шүү дээ. Өнөөдөр бид ахмадынхаа тэтгэврийг өсгөж чаддаггүй, багш, эмч нарын цалин гээд бөөн жагсаалт. Гэтэл Монголын ирээдүй цаана нь ийм хүүхдийн бэлгийн мөлжлөг гэж асуудалд унаад, 6 жилийн өмнө энэ нас барсан энэ Эпштейн гэдэг энэ дэлхий даяар алдартай нөхрийн зохион байгуулалттайгаар бүүр ОТ-н Дубайн гэрээ хүртэл энэ дээр холбогдож байна шүү дээ. Ийм ноцтой асуудал байж байхад бид нэг цахим мэдээн дээр гарсан мэдээлэл гэж хэлж байж ерөөсөө болохгүй юм. Бусад орнууд энэ дээр Хянан шалгах түр хороо байгуулаад, хууль хүртэл батлаад, арга хэмжээ аваад явж байна шүү дээ. Бид яах юм бэ? Хэд хэдэн гардаг байнгын гардаг хэдэн нөхдүүд одоо буцаад л албан тушаал авах гээд ингээд л явж байгаа юм. Ийм ноцтой асуудлыг ингэж зүгээр өнгөрөөж болохгүй гэж бодож байна.

**Б.Баярбаатар:** Батнайрамдал гишүүн үг хэллээ. Асуулт асуусан уу? 4 номер, Амарсайхан сайд хариулъя.

**С.Амарсайхан:** Түрүүн би хэлсэн. Энэ асуудлууд дээр энэ 3 чиглэлээр тусгай ажлын хэсэг байгуулж ажиллана гэж. 1 дүгээрт нь энэ хүний наймаа, 2 дугаарт нь цахим гэмт хэрэг, 3 дугаарт нь цар тахал юу хар тахал энэ хар тамхитай холбоотой асуудал байгаа юм. Тэгээд зарим ажлууд явж байгаа. Би энэ дээр минутаа нэмээд авчихна шүү даргаа. Нэг зүйлийг хамгийн түрүүн тодорхой хэлчихье гэж бодож байгаа юм.

Энэ цагдаагийн байгууллагын орон тоог хасчихсан 700-гаар өнгөрсөн жил, нөгөө хэмнэлтийн 9 хувь гээд. Тэгээд маш олон албад ажлаа хийхэд хүндрэлтэй

бөгөөд ачаалал өндөртэй, хүрч ажиллаж чадахгүй ийм нөхцөл байдал байгаа. Мэдээж энэ асуудлууд зөвхөн цагдаагийн байгууллага дангаараа хийх ажил биш, мэргэжлийн болон бусад холбогдох байгууллагууд хамтарч ажиллаж байж шийднэ. Эпштейний гээд байгаа асуудал энэ бол Монгол Улсын гадаад нэр хүнд, дотоод аюулгүй байдал, энэ болзошгүй ирээдүйд учирч болзошгүй нийгмийн аюулгүй байдал, энэ улс төрийн нөхцөл байдалтай шууд холбоотой учраас энэ дээр үндэсний аюулгүй байдлыг хангах талаасаа ч тэр, дотоодын аюулгүй байдлыг хангах талаасаа ч тэр, энэ улс орныхоо нэр төрийг хамгаалах чиглэлээсээ ч тэр аль алинаас нь үзэхэд бид бол холбогдох байгууллагуудын оролцоотой ажлын хэсэг байгуулж, өргөтгөсөн маягаар ажиллаж, энэ олон яригдаад байгаа асуудлууд дээр мэргэжлийн экспертүүд, мэргэжилтнүүдийг оролцуулах замаар тодорхой хугацаанд нарийн дүн шинжилгээ хийж, бодитой мэдээллүүдийг олон нийтэд өгнө.

Ямар нэгэн асуудал байгаа бол тэрийг эргэлзээгүй тайлах ёстой. Хэрвээ манай улсад хамааралгүй сенсац, эсвэл зүгээр сураг төдий асуудлууд байгаа бол тэрийг бас бид мухарлах ёстой. Яг ямар түвшинд, ямар хүмүүс оролцоотой байсан юм, ямар асуудлууд дээр уулзалт ярианууд явж байсан юм, тэрний үр дүн, эсхүл болбол сөрөг, эерэг үр дагаврууд юу байсан юм гэдгийг маш тодорхой болгох үүднээс ажлын хэсэг байгуулж мэдээлэл өгөх нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгээд энийг та бүхэнд албаны шугамаар явцын мэдээллүүдийг хүргэе.

**Б.Баярбаатар:** Батнайрамдал гишүүн 1 минут тодруулга.

**О.Батнайрамдал:** Би энэ Эпштейний файлуудыг өөрөө үзсэн л дээ. Би ямар өнцгөөс үзэж байна вэ гэхээрээ ОТ байна уу, ОТ-той холбоотой асуудал байна уу гэж хайж үзсэн. ОТ бол тэр чигээрээ гарч ирж байна. Тэгэхээр ОТ-н асуудлыг дандаа нэг гаднын мэдээллээс олж мэддэг, өнгөрсөн хойно нь олж мэддэг ийм үйл явц сүүлийн 16 жилийн турш болж ирж байгаа юм. Хамгийн сүүлдээ явсаар байгаад энэ алдарт Эпштейний файл дотор хүртэл гарч ирэх ч гэж дээ тэгээд. Тэгээд энэнтэй холбогдсон хүмүүс тэр алдарт Улсын Их Хурлын хүчингүй болгож цуцалсан, жинхэнэ Монгол Улсад хор учрал учруулсан энэ гэрээг байгуулсан Ерөнхий сайд Сайханбилэг, тухайн үедээ гал тогоог нь барьж байсан Баярцогт нь ингээд дэвшээд л яваад байгаа юм. Энийг л би ойлгохгүй байгаа байхгүй юу. Үгүй ээ яасан дарлуулж ханадаггүй юм, үгүй ээ яасан энэ асуудлыг олон улсын мэдээллээс аваад байхад.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

**С.Эрдэнэболд:** Энэ цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний санал гэдэг дээр 5 зүйл байна. Тэгэхээр мэдээж зарим ихэнх зүйл нээлттэй, ингээд тайлбарлаад ярьж байгаа үндэслэлээ гаргаж байгаа. Мөн ажил хэргийн шугамаар хаалттай ярих зайлшгүй сэдвүүд байх боломжтой байгаа. Тэрийг жич ХЗБХ-н дээр Хууль зүйн сайд яг энэ хаалттай оруулж ирж ярих зүйлүүдээ ярих нь зөв байх гэж үзэж байна.

Тэгэхээр 1 дүгээрт тэр шууд мэдээлэл солилцох, хамтарсан ажиллагааг явуулах тогтолцоог бүрдүүлэх холбогч офицер гээд байгаа шүү дээ. Энэ мэдээж Гадаад яам болон ТЕГ гээд олон салбарын байгууллагуудтай хамтрах зүйл учраас яг энэ талаарх мэдээллээ албан шугамаар нарийвчлалд хүсэлтээ ХЗБХ-нд ирүүлмээр байна. Энийг бүүр албан ёсоор.

2 дугаарт. ХХГХ-ийн хохирлын тусгай дэд сан байгуулах гэж байгаа. Энэ сангийн жишээлбэл юу нь орлого буюу бүрдүүлэлт нь хаанаас яаж бүрдэх юм бэ, ямар шалгуураар зарцуулалт нь явах юм бэ гэсэн энэ төсөөлөл, олон улсын судалгаа саналаа ирүүлээч ХЗБХ-н дээр. Мөн гэмт этгээдийн ашиг орлогыг хурааж, хохирогчдод нөхөн төлбөр олгох механизм гэж байгаа. Энэ жишээлбэл ямар хэмжээний төлбөрийн тухай, ямар хэмжээний төсөөллийн тухай ярьж байгаа юм бэ? Энэ талаарх нэг нэгдсэн мэдээллийг өгөөч. Тэгээд эдгээр мэдээллийг Хүний эрхийн дэд хороонд Баасанжаргал дарга дээр хаяглаад бидэнд ирүүлээч.

Дараа нь тэр хохирогч төвтэй нэгдсэн үйлчилгээний төв байгуулах гэж байгаа. Энэ төвийн функц, ажиллах горимыг яг юу гэж харж байгаа юм бэ, ямар төсөөлөл байгаа юм бэ? Ерөнхий ингэмээр байна, ингэмээр байна гэхээсээ илүүтэйгээр маш тодорхой алхам нь implementation буюу хэрэгжүүлэлт болох хэмжээнд бидэнд санал ирүүлээч.

4 дүгээрт, тэр Хүүхдийг улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам гээд 2.1.4-д заасан зүйл, заалтыг шинэчлэн боловсруулах гэж байгаагаа яг ямар үндэслэлээр, ямар өөрчлөлийг, яаж шинэчлэн боловсруулах гээд байгаа юм бэ гэдэг саналаа мөн энэ Хүний эрхийн дэд хороонд ирүүлээч.

Дараад нь 5 дугаарт, тэр тайчих үзүүлбэртэй баар, караокены чиглэлээр үйл ажиллагаа явуулж, бусдыг биеэ үнэлэхийг зохион байгуулах, хүн худалдаалах гэмт хэргүүд бүртгэгдэж эхэлсэн. Хар тамхи, мансууруулах бодис, мөрийтэй тоглоом зэрэг бусад төрлийн гэмт хэрэгтэй хавсран үйлдэгдэж байгаа гэж байгаа шүү дээ. Яг энэ дээр жишээлбэл тоо статистик, гэмт хэргийн гаралтын шинж байдлыг гаргаач? Ингээд энийг ер нь бид дээрх арга хэмжээнүүдийг авсан тохиолдолд ямар үйлдэл, үр дүн гарах вэ гэдэг ийм. симуляц байдлаар төсөөт аргын загварчлалын үр дүнг бидэнд ирүүлээч. Цагаа нэмж авч болох уу даргаа?

**Б.Баярбаатар:** Эрдэнэболд гишүүнд 1 минут нэмээд өгчихье.

**С.Эрдэнэболд:** Энэ дээр жишээлбэл Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс ч гэдэг юм уу эдгээр дээр бүтэц орон тоог бэхжүүлэх, чадавхжуулах гэж байгаа. Энэ дээр яг тодорхой саналаа яамны түвшинд юу хийх юм, Засгийн түвшинд юу хийх юм, энийг дэмжихийн тулд тухайлбал ХЗБХ-ноос ямар үйлдэл, шийдвэр гаргалтыг та нар хүсэж байгаа вэ энэ төлөвлөгөөгөө маш тодорхой бидэнд ирүүлээч. Одоо ерөнхийдөө танилцуулгыг ойлгож байгаа ч гэсэн шууд шийдвэр гаргах ийм саналуудыг та ирүүлээч.

Дараа нь 6-д нь болохлоор тэр AI тухай яримаар байна. Сүмбээ гээд программаар гарч ирээд тэр тодорхой энэ гэмт хэргийн хохирогч бий болгох нөхцөл байдал руу оруулаад байна шүү дээ. Тэгээд энийг ингээд тодорхой хаягуудыг хаасан гэж хэлээд байна. Энэ бол одоо байгаа зүйл дээр шинж тэмдгийн, уучлаарай юмаа дуусгасангүй минут дуусчихлаа, нэг яачхаач тэгэх үү?

**Б.Баярбаатар:** 1 минут сунгаад өгчихье.

**С.Эрдэнэболд:** Тэгэхээр одоо нөгөө байгаа зүйл дээр дүн шинжилгээ хийгээд хаахаас гадна, энэ ХХГХ-ийн хохирогч болж болзошгүй тэр зан төлөвтэй байгаа, энэ сурталчилгаа хийж байх магадлалтай энэ зүйлийг хиймэл оюун буюу бүтээмэл оюунаар AI-аар ингээд тандан судлах талаар та нар энэ дотор

төлөвлөгөөндөө оруулаач. Өөрөөр хэлбэл гарсан хэргийг яаж хаах вэ гэхээсээ илүүтэйгээр гарах болзошгүй нөхцөл байдалд бид яаж урьдчилан сэргийлэх вэ гэдэг дээр хиймэл оюун ашиглаж яваач. Энэ маш олон улсад ашиглаад байгаа юм байна лээ.

Тэгээд сая тэр нэг Эпштейн энэ тэртэй холбоотой зүйл дээр, зүйл гараад байна. Энийг яг энэ Хууль зүйн сайд яг энэ ажлын хэсгээ маш ойрын хугацаанд зарлаад явахгүй бол үнэн ч юм шиг, худлаа ч юм шиг энэ байдал нь өөрөө улс төржилтийн шалтгаан болоод нэг намын ч гэдэг юм уу лидерүүд рүү зохион байгуулалттай дайрах хэрэгсэл маягаар харагдах гээд байгаа учраас үнэн, худлын завсар 4 хуруу зай гэдэг шиг яг энийг тодорхой нотлох баримтад суурилсан байдлаар.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** 5 номер хариулах уу? Амарсайхан сайд, Амарсайхан сайд хариулъя.

**С.Амарсайхан:** Энэ асуудлаар ер нь сая ярьснаар нэг ийм эргэлзээ хардлага байгаа бол тэрийг нь тайлах, нэг талд нь ил тод мэдээллээр олон нийтийг хангах чиглэлээрээ ажлын хэсэг зохион байгуулагдаад явна, шуурхай зохион байгуулна 1 дүгээрт.

2 дугаарт, энэ асуудал хүний наймаатай холбоотой асуудал бол ойрын хугацаанд зөвхөн Хууль зүйн яам, үгүй ээ Байнгын хороо төдийгүй ер нь энэ Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, Боловсролын яам гээд энэ нийгмийн чиглэлийн оролцоотой төрийн захиргааны төв байгууллагуудыг оролцуулж, нэлээн хаалттай мэдээлэл солилцож, энэ дээр цогц арга хэмжээ авахгүй бол энэ өөрөө ихээхэн анхаарал татсан асуудал болж байгаа. Сая хэлсэн орчин үеийн боолчлолын хэлбэр гээд төрөл бүрээр ажилд зуучилж байна. Цахим энэ халдлага, хүний наймаа энэ чиглэлийн гэмт хэргүүд улам нэмэгдэж байна. Энэнээс урьдчилан сэргийлэх ажлуудыг хэрхэн зохион байгуулах тухай асуудал бас их өргөн хүрээнд цогцоор нь ярьж, ойрын хугацаанд тодорхой үе шаттай ажлуудыг хийх талаар Эрдэнэболд гишүүний яриад байгаа асуудал дээр бид дотооддоо ярьж байгаа зүйлүүд бий. Энэ чиглэлээр мэргэжлийн албад, холбогдох байгууллагууд төлөвлөгөөгөө ойрын хугацаанд тодотгоод, тэгээд Байнгын хороо болон бусад хамтарсан уулзалтууд дээрээ танилцуулъя гэж байгаа. Энийг бид дараагийн удаа бол хаалттай хийх ёстой гэж үзэж байна.

**Б.Баярбаатар:** Гишүүд асуулт асууж дууслаа. Би ганц нэг асуултыг асууна, үг хэлнэ. Тайлантай танилцлаа. Мэдээж энэ 9 оронд, 9 хүн ажиллаж байгаа юм байна тийм ээ. 9 хүний бүрэлдэхүүнтэй энэ томоохон ХХГХ-тэй яаж тэмцэж барах вэ дээ ер нь.

Дээр нь энэ хүн худалдаалах асуудал чинь энэ Зүүн Өмнөд Азийн орнууд руу орчихсон байна гэж ёстой бодсонгүй. Мьянмар, Камбож гээд. Хууль зүйн сайд энэ дээр бүүр онцгой анхаарах ёстой, энэ цагдаа дангаараа дийлэхгүй. Өнөөдөр энэ ХЗБХ бодлого гаргах ёстой юм байна, ХЗДХ-ийн сайд өнөөдөр энэ дээр салбарын хэмжээний бодлого гаргах ёстой юм байна. Энэ дотроо тэр ажлын хэсгүүдээ байгуулаад, цагдаагийн байгууллагаа чадавхжуулж, дэмжлэг үзүүлж ажиллахгүй бол статистик тоог бид танилцаад байх шиг байна. Тэгээд 9 хүний бүрэлдэхүүнтэй энэ том асуудалд яаж хандах вэ гэдэг чинь өөрөө нэг асуудал байгаа.

Дээр нь энэ олон гишүүд энэ Жеффри Эпштейн гэдэг хүнтэй холбоотой асуудлыг нэлээд ярилаа. Жеффри Эпштейн дэлхийд муу муухайгаараа жигшигдэж, үзэн ядагдаж байгаа ийм хүн. Олон мэдээлэл нь албан ёсны эх сурвалжаас ил тод болсон. Харамсалтай нь энд өнөөдөр Монгол Улсын төрийн тэргүүнээр ажиллаж байсан 2 Ерөнхийлөгч, Ерөнхий сайдаар ажиллаж байсан нэг хүн нэр холбогдсон асуудал өнөөдөр АНУ-ын албан ёсны веб сайт дээр ил тод мэдээлэл гарлаа. Жеффри Эпштейнтэй холбоотой 3,5 сая хуудас материал ил тод болсон шүү. Тэгэхээр эндээс үзэхээр Гадаад хэргийн сайд асан, Элбэгдорж Ерөнхийлөгчийн зөвлөх асан Пүрэвсүрэн гэдэг хүний одоогийн байдлын шүүлтээр үзэхэд 219 удаа энэ хүний нэр дурдагдсан байна. Либерти Партнерс ХХК-ийн захирал Ганбат гэдэг хүний нэр энэ захидал харилцааны явцад 194 удаа дурдагдсан байна. Монгол Улсын Ерөнхийлөгч асан Халтмаагийн Баттулга гэдэг хүний нэр 81 удаа дурдагдсан байна. Монгол Улсын Ерөнхийлөгч асан Цахиагийн Элбэгдорж гэдэг хүний нэр 46 удаа дурдагдсан байна. Энэ цаашаа шүүлт үргэлжилж байгаа шүү.

Дээр нь Эпштейн гэдэг хүн 3 чиглэлээр өнөөдөр дэлхийд үйл ажиллагаа явуулж байсан нь тогтоогдоод явж байгаа. 1 дүгээрт нь бэлгийн мөлжлөг буюу бага насны хүүхдийн хүчирхийлэгч, 2-т энэ мөнгө угаагч, санхүүгийн гэмт хэрэгтэн, тэгээд 3-д улс орны эрх бүхий албан тушаалтанд улс төрийн нөлөөлөл үзүүлэх лоббид гэж. Тэгээд энэ 3 нь хоорондоо уялдаатай. Тэгээд манай гишүүд ч хэлж байх шиг байна. Жишээлбэл тэр Английн хунтайж Эндрю /Andrew/ гэдэг хүн бүх хэргэм зэргээ хураалгаад, бараг Английн иргэд нь улсаасаа хөөх талын асуудлыг ярьж байна. Олон удирдах албан тушаалтнууд өнөөдөр огцроод, хууль хяналтынхаа, тухайн улсынхаа хууль хяналтын байгууллагадаа шалгагдаад явж байгаа.

Элбэгдоржийг төлөөлж энэ Пүрэвсүрэн гэдэг хүн бол олон улсын захидал харилцаа, олон удаагийн захидал харилцааг энэ Жеффри Эпштейн гэдэг хүнтэй бичсэн байгаа. Энэ ил тод болсон. Үүний нэг юу бол Нью Йоркт уулзахдаа нэг сюрпризтэй ирнэ, тэр нь Монгол охин байна гэж байгаа юм. Тэгтэл нөгөөх нь хариу ямар сайхан мэдээ вэ, удахгүй уулзацгаая гэсэн хариу ирсэн мэйл нь ил тод байна шүү дээ. Тэгээд энэ охин явсан уу Америк руу, энэ хүний наймааны асуудал биш үү, бэлгийн хүчирхийллийн асуудал байж болох уу? Явсан бол энэ охин эргэж ирсэн үү, өнөөдөр амьд сэрүүн байна уу энэ охин? Дээр нь тэр Элбэгдорж Ерөнхийлөгчийн өргөж аваад, өсгөж хүмүүжүүлээд байсан хүүхдүүд өнөөдөр нэр устайгаа хаана байна вэ? Цагдаагийн байгууллага энийг тодруулсан уу та нар?

Мөнгө угаах гэмт хэргийн талаар энэ Элбэгдоржийн олон сая доллар үнэ бүхий уран зураг, үнэт зүйл, эдлэн газар, house худалдаж авахыг санал болгосон. Нийт өртөг нь 500-гаад сая долларын өртөгтэй. Монгол Улсын Ерөнхийлөгч өнөөдөр хэдэн төгрөгийн цалин авдаг юм бол? Энэ хүн Монгол Улсын Ерөнхийлөгчөөр 2 удаа сонгогдоод, дараа нь энэ АНУ-д очоод ажиллаж, амьдарч байхдаа энэ хэмжээний мөнгийг хуримтлуулах ийм боломж бололцоо нь байдаг юм болов уу? Авсан, үгүйг нь би мэдэхгүй байна. Цааш нь нягталж шалгах зайлшгүй шаардлага байгаа. Тэр Их тэнгэрт байгаа тэр байсан 21 уран зураг алга болсон гэсэн мэдээлэл байгаа. Энэ дээр цагдаагийн байгууллага мэдээлэл байгаа юу та нар? Энийг тодруулах шаардлага байна.

Тэгээд ер нь ингээд хараад байхад тэр Булгантуяа гишүүний хэлж байгаа үнэн байх. Янз бүрийн party дээр нөлөө бүхий албан тушаалтнуудыг урьж оролцуулж, бэлгийн хүчирхийлэл үйлдүүлж, түүнийгээ дүрс бичлэгт баримтжуулан авч, буцааж тэрүүгээрээ улс төрчдийг шантаажилж, тухайн улсад нь улс төрийн

шийдвэрийг гаргуулдаг байх гэсэн ийм нөхцөл байдал харагдаад байгаа юм энэ дээр. Энэний нэг тод жишээ бол тэр Батнайрамдал гишүүний хэлээд байгаа энэ Дубайн гэрээ. Одоогоос 12 жилийн өмнө тэр Дубайд болсон морин уралдааны нэг билетийн үнэ нь 23 сая төгрөг Монгол төгрөгөөр. Манай эрх мэдэлтнүүд очиж үзсэн байгаа шүү дээ. Дубайн нөлөө бүхий этгээдүүдтэй Жеффри Эпштейний зуучлалаар. 12 жилийн өмнө гэхээр 14 он, 15 онд Дубайн гэрээ байгуулагдсан шүү дээ. Тэгэхээр энэ хардах нэг үндэслэл мөн үү гэвэл мөн шүү. Шалгах ёстой үндэслэл мөн үү гэвэл мөн.

Дээр нь энэ Бодь компанийн нэг хэсэг нь Голомт банк энэ Эпштейн гэдэг хүнд очиж Монгол Улсын байгалийн баялагтай холбоотой мэдээллийг танилцуулсан баримт гарч ирсэн. Ингэж болдог юм болов уу? Тэгэхээр би ХЗБХ-ны гишүүний хувьд өнөөдөр энэ Хүний эрхийн дэд хороог удирдаж байсан манай Эрдэнэболд гишүүн энд сууж байна. Өнөөдөр Баасанжаргал гишүүн гадаад томилолттой байгаа. Энэ хүний эрх зөрчигдсэн байх магадлал өндөр байна. Хүний худалдаа, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн асуудал, цаашлаад олон сая долларын авлигын асуудал, цаашлаад Монголчуудын байгалийн баялгийг, боломжийг хулгайлсан асуудал гэсэн олон зүйлүүд хөндөгдсөн байх ийм үндсэн шалтгаан байгаа учраас би Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол зохион байгуулах санаачилгыг Улсын Их Хурлын гишүүнийхээ зүгээс би өнөөдөр гаргаж байгаа юм. Энэ асуудалтай холбоотой.

Энэ дээр би хууль зүйн салбар, цагдаагийн байгууллага, Хүний эрхийн дэд хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс /ХЭҮК/ олон байгууллага дэмжлэг үзүүлж ажиллах байх гэдэгт би бүрэн итгэлтэй байгаа. Улсын Их Хурлын гишүүд энэ дээр улс төржихгүйгээр дэмжлэг үзүүлж, гарын үсэг зурж, энэ шийдвэрийг баталгаажуулна гэдэгт би бүрэн итгэлтэй байгаа. Эрдэнэболд гишүүн түрүүн хэлж байна. Үнэн, худал нь мэдэгдэхгүй олон мэдээллүүд гараад ирлээ гэж. Парламент өнөөдөр хяналт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. Энэ хяналт хэрэгжүүлэх чиг үүргийнхээ дагуу эдгээр асуудлуудыг мухарлаж байх нь зөв. 2009 онд байгуулагдсан ОТ гэрээний үр ашиг өнөөдөр Монголд хүртсэн хүн байвал гаргаад ирээрэй. 19 онд хүртэнэ гэсэн үр өгөөж өнөөдөр 26 он хүртэл хүртэгдээгүй байгаа. Баярцогт гэж хүн өнөөдөр Монгол Улсад ямар том гай авчирсныг бид цаашдаа олон талаар нь дэлгэж ярих болно.

Өнгөрсөн жил ОТ түр хороо байгуулагдаж, Батнайрамдал гишүүн ахалж олон зүйлийг ил болгож, иргэдийг мэдэх эрхээр хангасан байж байгаа шүү. Парламент өөрөө хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ онцгой хэрэгжүүлж, цаашлаад энэ өнгөрсөн олон жилийн хугацаанд хөшигний ард явагдаж байсан олон зүйлийг ил тод өнөөдөр энэ 126 гишүүнтэй парламент харин ил тод болгож байгаа шүү гэдэг нэг талын давуу тал. Тийм учраас би бас гишүүдээсээ дэмжээсэй гэж хүсэж байна.

Мэдээлэл хийсэн албан хаагчид энэ саяын миний үндэслэлүүдтэй холбоотой зүйлүүд дээр ер нь мэдээлэл шалгалт хийж байгаа юу, хийсэн үү? Дээр нь манай цагдаагийн Тэргүүн дэд дарга цахим орчинд гарсан гэж битгий ярь. Энэ АНУ-ын Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны веб сайт дээр тавигдсан 3,5 сая хуудас материал дотор, өнөөдөр энэ 3,5 сая хуудас материал дотор шүүлт үргэлжилж байна. Хариултаа тодорхой авчихъя. 4 номер.

**Э.Ганчулуун:** Таны асуултад хариулъя. Мэдээж цагдаагийн байгууллагаас, хууль хяналтын байгууллагаас энэ асуудал дээр Эпштейний холбоотой асуудал дээр шалгалтын ажил, судалгаа юмнууд хийгдээд явж байгааг би түрүүн бас хэлсэн байгаа.

Мөн энэ дээр тэр 21 уран зургийн гэдэг асуудал дээр цагдаагийн байгууллага дээр шалгагдаж байгаа байгаа. Энэ дээр би ямарваа нэгэн гэмт хэргийн талаар юмыг дэлгэрэнгүй ярих боломжгүй байна.

Элбэгдоржийн 23 хүүхэд гэдэг асуудал дээр цагдаагийн байгууллага судалгаа юмнуудыг нь хийж үзсэн байгаа. Энэ дээр 3 хүүхэд нь 25 онд улсын хилээр насанд хүрээд гарчихсан, бусад хүүхдүүд нь Монгол Улсад өнөөдөр амьдраад байж байгаа гэдгийг хэлье. Тийм юм байхгүй, одоогоор тийм юм тогтоогдоогүй.

**Б.Баярбаатар:** Ер нь дараа дараадаа энэ нээлттэй сонсгол зохион байгуулах ажил явагдана. Энэ дээр цагдаагийн байгууллага идэвхтэй оролцож, хамтарч ажиллаарай гэж хүсэж байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгье? Булгантуяа, Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн үг хэлнэ.

**Х.Тэмүүжин:** ХХГХ энэ төрлийн гэмт хэргүүд ер нь олон улсад манайхаас түрүүлээд энэ төрлийн гэмт хэрэгтэйгээ тэмцэх чадвартай болчихсон улс орнуудын туршлагаар бид одоо хөдлөх цаг болсон байна. Улс орнууд энэ төрлийн гэмт хэргээ юу гэж гарчиглаж байна вэ гэхээр үндэстэн буюу улс дамнасан гэмт хэрэг гэж хэлж байна. Зохион байгуулалттай байдаг, эдийн засгийн маш тодорхой сонирхолтой, бараг бизнес хэмжээнд босчихсон байдаг. Дотор зохион байгуулалтынхаа хүрээнд хохирогчоо олж авах үйл ажиллагаа нь нэг улсын газар нутаг дээр ерөөсөө биш, хэд хэдэн улс дамнаж дамжиж хийгддэг. Ганц хүн худалдаалах биш, мөнгө угаах, хар тамхи гэх мэтчилэн. Тэгээд энэ гэмт хэрэгтэй зүгээр цагдаагийн өнөөдрийн бидний арга хэрэгслээр тэмцээд ямар ч үр дүн хүрэхгүй. Бидний сүртэй нэрлэдэг нөгөө тагнуул гэж ярьдаг, яг тагнуул ч биш л дээ. Илүү мэдээлэл боловсруулдаг тэр арга хэрэгслээрээ угтан ажиллаж байж зохион байгуулалтыг нь, 1, 2 хэргийг дагаж байж, дотор нь хүн оруулж байж, дараа нь зогсоох, таслан зогсоох. Гэхдээ зүгээр таслан зогсоох биш эдийн засгийнх нь эх үүсвэр лүү цохилт өгч байж зогсоодог энэ төрлийн арга барилаар тэмцдэг.

Тэгээд энэ улс орнууд энэ төрлийн арга барилаар яаж тэмцэж байна вэ гэхээр ерөөсөө л Мөрдөх алба байгуулж тэмцэж байна. Мөрдөх алба байгуулаад, ганц Мөрдөх алба биш, энэ чинь нөгөө улс дамнасан учраас, гэмт хэрэгтэй холбогдож байгаа гарч байгаа бүс нутгууд руугаа хууль зүйн атташе томилж байгаад асуудалтайгаа тэмцэж байна. Тэгээд бид ингээд гадаад харилцаа эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээсээ гадна энэ өөрөө ганц дотоод хууль сахиулах үйл ажиллагаатай холбоотой биш учраас бие бүрэлдэхүүний хувьд, боловсон хүчний хувьд, арга барилын хувьд, зохион байгуулалтын хувьд яах аргагүй Мөрдөх албаны түвшинд очихоос өөр аргагүй байна.

Уул нь 24-өөс 28 оны ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1.8-д ийм зорилт орсон. Энийгээ ЗГ биелүүлэх ёстой. Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх Мөрдөх албыг байгуулж, мэргэшүүлэх, гадаад хамтын ажиллагааг сайжруулна гэсэн зорилт бүүр биччихсэн байгаа цагаан дээр хараар. Одоо ЗГ энэ

албаа байгуулахгүй юм уу, энэ ажлаа хийхгүй юм уу. Энэ ажлаа хийж байж энэ төрлийн гэмт хэрэгтэйгээ бид тэмцэж чадна шүү дээ. Одоо байгаа цагдаагийн арга барил, нөөц хүчээр тэмцэхгүй. Хар тамхитай тэмцэх боловсон хүчин бэлдээд ирэхээр суманд хуваарилаад явуулчихдаг бүтэц чинь ажиллахгүй шүү дээ. Тийм учраас одоо Хууль зүйн яамныхаа түвшинд мөрдөх холбоо байгуулах хэрэгтэй. Гадагшаагаа хууль зүйн атташе томилдог болох хэрэгтэй. Харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээнүүддээ сайжруулах хэрэгтэй. Энэ хүн худалдаалах, хар тамхи гэх мэтчилэн үндэстэн дамнаж байгаа гэмт хэргүүдийнхээ эх үүсвэрүүдийг олох хэрэгтэй. Эдийн засгийн зохион байгуулалтыг нь угтан тагнаж мэдэх хэрэгтэй.

Дараа нь цохилтоо өгөхдөө томоохон хэмжээний эдийн засгийн хохирол амсах хэмжээнд бүүр зохион байгуулалттайгаар, тактиктэйгаар ажлаа хийх хэрэгтэй. Зүгээр гудамжинд хар тамхи хэрэглээд гүйж байгаа хүмүүсийн араас хөөцөлддөг биш, цаад эзэд нь, эдийн засгийн ашиг олоод байгаа, зохион байгуулалтыг нь хийгээд байгаа, гадагшаа, дотогшоо хэлхээ холбоо тогтоогоод байгаа тэр сүлжээг нь таслан зогсоох хэрэгтэй. Хүн худалдаалах ялгаагүй, мөнгө угаах ялгаагүй. Одоо мөнгө угаах нь бүүр гэмт хэрэг болгоны ард сүүл зүүдэг дагавар болоод хувирчихлаа. Мөнгө угаах гэдэг чинь бүр өөр гэмт хэрэг шүү дээ. Гэмт хэргийн улмаас олсон мөнгөө завшиж байгаа нөхрийг мөнгө угаах гэж хэлж болохгүй шүү дээ. Гэмт хэргийн улмаас их хэмжээний ашиг олоод, эдийн засгийн бүтэц үүсгээд, тэрийгээ цэвэрлэх гэж байгаа банк санхүүгийн тогтолцоотой өөр.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** 1 минут нэмээд өгчихье Тэмүүжин гишүүнд.

**Х.Тэмүүжин:** Өөр олон эдийн засгийн механизмтай, тэр сүлжээгээ л илрүүлж, таслан зогсоох тухай ярина шүү дээ. Тэгэхгүй бол бид чинь зохион байгуулалттай энэ үндэстэн дамнасан гэмт хэрэгтэйгээ тэмцэж чаддаггүй. Нэг юу гэдэг юм ахуйн хэмжээний гэмт хэргээр шоу хийдэг байгууллагууд болоод хувирчихлаа. Энийгээ ЗГ ажлаа хийх ёстой. УИХ баталчихсан тогтоол, Улсын Их Хурлын шийдвэр байна. Сая Хүний эрхийн дэд хороо болон ХЗБХ санаачлаад, УИХ дахиад баталсан энэ гэрч, хохирогчийг хамгаалах болон энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэгтэйгээ тусдаа дагнасан байгууллага байгуулах тухай. Гэхдээ энэ хоёрыг хольж болохгүй шүү. Мөрдөх алба тусдаа шүү.

Цахим гэмт хэрэг сая хэллээ, тайлан дотор тодорхой гарч байна. Энэ өөрөө олон төрлийн гэмт хэрэг холилдож хийгддэг болоод хувирчихлаа. Зохион байгуулалт нь биднүүсийн зохион байгуулалттай бүлэг биш, нэг удаагийн зохион байгуулалт дээр түшиглэж хийдэг болоод хувирчихлаа. Гэмт хэргийнхээ онцлогоос шалтгаалаад арга барилуудаа өөрчилж, тэр боловсон хүчнээ сайжруулах тэр чиглэл рүүгээ яваач.

**Б.Баярбаатар:** Тэмүүжин гишүүний хэлж байгаа санал чухал байгаа шүү. Өнөөдөр жишээлбэл манай цагдаагийн байгууллагын Тэргүүн дэд дарга, Хүн хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга 2-ын мэдээлэл дотоодын асуудал ярьж байгаа. Хэдий гадаадтай холбоотой үйл ажиллагаа чинь дутмаг байгаа гэдгийг та бүхний мэдээлэл өөрсдөө харуулчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ Хууль зүйн сайд энэ дээр бодлого гаргаад, энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс тэр Мөрдөх алба байх юм уу, ямар алба нь байх юм тэгээд тэр нэршил юмнуудаа санал хэлж байгаа гишүүдтэй зөвлөлдөж байгаад энэ асуудлаа

урагш нь явуулах нь зөв байх. Ажил явуулах үүднээс. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн санал хэлнэ.

**Х.Булгантуяа:** Би бас бид ер нь Panama Papers Эпштейн файлын дараагаар дэлхийн улс орнууд 1 дүгээрт цахим хэрэглээ улам нэмэгдэж байгаа энэ цаг үед бидний communication юм хум алдагдах вий, дээрээс нь нэмээд үүн дээр олон янзын, ялангуяа нууцтай холбоотой ч байдаг юм уу, төрийн энэ албан тушаалтнуудын хоорондын мэдээ мэдээлэл ингэж алдагдаж байгаа байдлуудыг бид олж уншлаа шүү дээ. Тэгэхээр үүнтэй холбоотой, ялангуяа цахим хэрэглээ нэмэгдэж байгаа энэ цаг үед Цахим хөгжлийн асуудлыг хариуцсан сайдтай ЗГ-ын ийм гишүүнтэй байгаа энэ цаг үед үүн дээрээ бид анхаарах цаг болсон гэж бодож байна.

Ер нь дэлхийн бусад улс орнуудаас Монголтой холбоотой хандалт хийгээд, янз янзын мэдээ мэдээллүүдийг аваад байдаг юм биш биз дээ? Түрүүн манай Батнайрамдал гишүүн бас хэллээ. Монголын байгалийн баялгийн асуудлыг гадаадын улс оронд хэдэн хүмүүс сууж байгаад л, бүгдээрээ хоорондоо яриад л шийдчихдэг юм байна. Дубайн гэрээ бол тэгж л зурагдсан юм байна. Улс орнууд хэдэн томчууд нь нийлж байгаад л ОТ-г ерөөсөө ингэж шийдье, Дубайн гэрээг ингэж байгуулъя гэдгийн араас. Тэгэхээр манай, үүний араас бид дахин ийм юм болохгүй байх арга хэмжээг авах зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа юм.

Дээрээс нь нэмээд төрийн нууцтай алба энэ ажиллаж байгаа албан хаагчдынхаа, ялангуяа дэлхийн бусад улс орнуудад очоод ийм уулзалтууд болж байгаа бол ийм юмнууд болж байгаа бол барьцаанд орчихгүй байдлаар яаж ажиллуулах вэ гэдэг дээрээ манай тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллагууд маань ажиллахгүй бол энэ бол цаашдаа ер нь санаа зовсон асуудал болж хувирч байна. Хамгийн санаа зовмоор. Эндээс дэлхийн улс орнууд тийм дүгнэлт хийгээд байна. Цаашид энэ албан хаагчдаа ямар нэгэн байдлаар барьцаанд ороод, сүүлдээ улс эх орныхоо хувьд ашиггүй, алдагдалтай, эсхүл том групп компанид ашигтай ийм шийдвэрүүд гаргачих вий дээ, үүнээс бид хэрхэн, яаж хамгаалах вэ гэдэг дээр анхаарах цаг болжээ. Тэгээд үүн дээр манай ЗГ, ХЗДХ-ийн сайд ажиллахгүй бол бидний яриад байгаа өнөөдрийн асуудал бол дэлхийн улс орнуудад очоод өнөөдөр дараа нь үр дагаврыг нь бид энд нэг түр хороо байгуулаад л яриад байдаг.

Тэгээд шийдвэрүүд нь түрүүлж гарсны дараагаар үүний араас олон улсын шүүхээр яваад ч шийдэгддэггүй юм байна шүү дээ. Одоо ингээд Эрдэнэтийн гэрээний асуудал, Эрдэнэтийн 49 хувийн асуудал 10 жилийн дараа Монголын шүүхээр яваад шийдэгдэж чадахгүй байна гээд Хэрэг эрхлэхийн сайд нь Улсын Их Хурлын чуулган дээр тайлбарлаж байсан. Тэгэхээр дотооддоо ч шийдэж чадахгүй юм байна. Монголын байгалийн баялгийн асуудал бол гадаадад яригдаад шийдэгдэж байгаа юм байна. Тэгээд би үүнтэй холбоотойгоор хуралдаан даргалагчаа ер нь үүн дээр сонсгол зохион байгуулах нь зүйтэй. Түр хороо байгуулах ёстой юм уу, эсхүл нийтийн сонсгол явуулах ёстой юм уу ямар нэгэн байдлаар энэ асуудлыг ер нь нэг мухарлах нь зүйтэй гэж түрүүн бас Эрдэнэболд гишүүн хэлж байна.

Энэ зүгээр бид улс төржөөд байгаа юм биш. Яагаад гэвэл үүн дээр илэрч байгаа нэрснүүд нь энэ. Тухайн үеийн сонгуулийн асуудлыг ч гэсэн Ба, Бэ-гүй бичсэн байна лээ явцынх нь тухай, тэгээд зөвлөгөө авсан юм шиг байна. Тэгээд санхүүжилт явагдсан юм уу, үгүй юм уу тэрүүний тухай ч гэсэн нарийн судалж, цагдаагийн

байгууллагаас байдаг юм уу судалж үзмээр харагдаж байна. Нөгөө талдаа манай албан тушаалтнуудтай холбогдолтой тийм эвгүй бичлэг, дарамтлуулсан асуудлууд байдаг юм уу, үгүй юм уу? Тэрүүнийг та бүхэн маань Америкаас олж авахад хэцүү байгаа юм байна. Тэгэхээр үүн дээр нэг сонсгол явуулах нь зүйтэй байх хуралдаан даргалагчаа, тэгж энэ асуудлыг эцэслэх нь зүйтэй. Энэ чинь Монголын энэ том албан тушаалтнуудын нэр, асуудал, Монголын байгалийн баялгийн асуудал ийм удаа дараа. Дээрээс нь нэмээд хүн худалдаалах асуудал хүртэл удаа дараа дурдагдаад байхад Монголын төр, засаг үүнийг огт мэдээгүй юм шиг байж болохгүй. Гэрчийн хамгаалалтад байдлаар ер нь энэ хүн худалдаалахтай холбоотой гэмт хэрэгт өртсөн хүмүүс, тэр тусмаа ялангуяа том албан тушаалтан хэрвээ үүнийг хийсэн бол би эмэгтэй хүн гарч ирээд би энд өртсөн гэж хэлж чадахгүй байх гэж бодож байна. Тэгэхээр үүнийг та бүхэн маань бүүр онцгойлон анхаараарай. Энэ зүгээр нэг.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үг хэлнэ.

**С.Эрдэнэболд:** Тэгэхээр нэг ийм юм харагдаад байгаа юм. Эпштейн гэнгүүт одоо ингээд өнгөрсөн хугацааны юм яригдаж байна. Тэрний үр дагаврууд нь одоо яригдаад явж байна. Тэгэнгүүт дахиад одоо ч гэсэн ингээд өөр нэгэн нэртэй, ямар нэгэн, хэн нэгэн гадаад хүний ч юм уу нэртэй ийм мэдээлэл дамжуулдаг ч гэдэг юм уу, уулзалтууд ч гэдэг юм уу тэр нь Монгол Улсын бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх ч гэдэг юм уу, байгалийн баялагтай холбоотой асуудал дээр шийдвэр гаргалтад нөлөөлөх ч гэдэг юм уу ийм зүйл явагдаж байгаа байж болзошгүй. Тэгэхлээр яаж байна гэхлээрээ манайх гадаад бодлогын нэг цонх гэж хэлдэг шиг, үздэг шиг нөгөө талдаа үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх гээд бид бас яриад байгаа.

Тэгэхээр энэ ЗГ-ын гишүүд, Улсын Их Хурлын гишүүд, бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшний хүмүүс гадаад улсын хувь хүн, байгууллага, ААН-тэй уулзахдаа тодорхой протоколтой, стандарт байх ёстой. Монголоос очоод би сая ингээд өнгөрсөн жил Германы ЭСЯ-ан дээр очоод л мэдээлэл авч байхад хэд хэдэн газар мэдээлэл авч байхад яг манайхан бол очоод л юмыг дандаа шинээр ярьдаг. Нэг байгууллагатай уулзахдаа л өмнө нь өчнөөн удаа ирээд явчихсан, нөгөө Сингапурт очоод 100 хэд дэх зочин нь болж байна гэж Бямбацогт сайдын хэлдэг шиг очоод л бүхнийг эхнээс нь явдаг. Ямар ч төрийн ой санамж, өнгөрсөн хугацаанд хэн уулзаад, яасан, ийсэн талаар мэдээлэл байхгүй. Осолдохгүй төрийн 3 өндөрлөг гэж яригддаг Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд гадаад айлчлал, эсхүл гаднаас айлчлал ирэхэд бол нэг ийм айлчлалын ном гэж гардаг. Тэнд нь юу болсон юм, яасан ийсэн гэдэг лавлах байдгаас биш, бусад юмнууд байхгүй. Ялангуяа Монгол Улсын ҮАБЗ-д байгаа гишүүд гаднынхантай уулзсан тохиолдолд нэг бүрчлэн протокол нь тэмдэглэгдэж байх ёстой. Баярбаатар дарга мэдэж байгаа бид Япон явахдаа 48 хуудас протокол, уулзсан тэмдэглэлээ бичиж авчраад, Гадаад хэргийн сайдад хүлээлгэж өгч байсан. Яг энэ шиг юмыг нэг стандарт болгомоор байгаад байгаа юм нэг.

Дараагийн нэг асуудал нь цахим шуудангийн харилцаа холбооны асуудал. Жишээлбэл АНУ-ын Ерөнхийлөгчид нэр дэвшиж байсан Хиллари Родэм Клинтон /Hillary Diane Rodham Clinton/ албан бус хувийн хаягаасаа албаны ажлын мэйл бичсэн гээд шуугианд орж байсан. Энэ Солонгосын ял эдэлсэн Ерөнхийлөгч Пак Гын Хе /Park Geun-hye/ Ерөнхийлөгч одоо эдэлж байгаа. Энэ хүн бас яг хувийн мэйлээрээ харьцсан буюу өөрийнхөө мэйлээр туслахаараа ч билүү үзүүлсэн гээд

асуудалд орж байсан. Манайд ийм стандарт байхгүй. Их Хурлын гишүүний parliament.mn өргөтгөлтэй мэйлээр Их Хурлын гишүүд тэр болгон ашиглахгүй байгаад байгаа юм. Яагаад гэхлээр сервер нь болох юм бол gmail-ээс хурд багатай, маш тийм болхи, тэгээд spam руу орчихдог. Тэгэхээр яаж байна гэхлээр одоо бид google өргөтгөлтэй цахимаар харьцаж байгаа энэ нь тэгээд яг зөв юм уу, буруу юм уу гэдэг асуулт үүсчхэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ юу гэж байна гэхлээрээ бид яг энэ шинэчлэлийн асуудлаа нэг мөр болгоод, уулзалтын стандарт тодорхой болгоод, ямар нэгэн байдлаар дарга нар гаднын ч бай, дотнын ч бай хүмүүсийг ажлын бус цагаар уулзаж байгаа бол, ялангуяа шүүх эрх мэдлийн ч гэдэг юм уу, хууль, гүйцэтгэх, хэрэгжүүлэх прокурор ч гэдэг юм уу энэ хүмүүстэй уулзаж байгаа бол ямар журмаар, яаж уулзах юм. Дуудаад команд өгөөд байдаг гэдэг домог нь үнэн юм уу, эсхүл яг бодитойгоор уулздаг ч гэдэг юм уу энэ бүх зүйлийг нэг мөр болгохын тулд ХЗБХ-н дээр тодорхой санаачилга гаргаад, энэ Монгол Улсын төрийн албан хаагчдыг, нөлөө бүхий өндөр албан тушаалын шийдвэр гаргахад нөлөөлж байгаа улс төрчдийн гадаад, дотоод харилцааны стандартуудыг нэг цонхтой нь уялдуулж өгөх зайлшгүй шаардлага гарч байна.

Дараагийн зүйл, шүүхээр хэнийг ч гэм буруутай нь эцэслэн тогтоогдоогүй байхад бусдын нэр төр, алдар хүнд хамгаалагдсан байдаг. Тийм учраас яг энэ Эпштейнтэй холбоотой асуудал болон бусад асуудлууд дээр бид олон улсын эх сурвалжийг гишүүд маань аваад яриад байгаа бол энийг нэг мөр хэдүүлээ ойлгох ёстой юм. Тэгэхгүй болохлоор нөгөө уул мөн чанараас нь салгаад, улс төржиж байна гэдэг ойлголт руугаа хэлбийх хандлага байгаад байгаа учраас энэ дээр яг сонсгол нь байдаг юм уу, ямар нэгэн байдлаар эцсийн дүгнэлт хийх ёстой гэж би бодож байна.

**Б.Баярбаатар:** Баярлалаа тийм. Би санал санаачлагчийн хувьд нийтийн сонсгол зохион байгуулах нь зөв гэж харж байгаа. Эрдэнэболд гишүүнтэй санал нэг байна. Өнөөдөр шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй хэнийг ч бид гэм буруутайд тооцож болох үл болох ийм Үндсэн хуулийн зарчимтай. Тэр агуулгаараа энэ зарчимдаа нийцэж, нэгд бид хүний эрхийн зөрчил үүссэн байх магадлал өнөөдөр энэ нөхцөл зүйл дээр бас ажиглагдаж байгаа учраас энийг нягталж үзэх шаардлагатай гэж бодож байна. Энэ дагуу Улсын Их Хурлын ХЗБХ-ны дэргэдэх Хүний эрхийн дэд хороо болон Улсын Их Хурлын дэргэдэх байгууллага ХЭҮК-той энэ ХЗБХ-ноос хурал даргалагчийн зүгээс энэ саяын ярьсан сэдэвтэй холбоотой Жеффри Эпштейн гэдэг хүнтэй холбоотой, ялангуяа хүний эрхийн зөрчил, хүний наймаа, бэлгийн мөлжлөг гэсэн талаар холбогдох материалуудыг цуглуулах ийм чиглэлийг өгье.

Дээр нь ХЗДХЯ, ЦЕГ, ХЗДХ-ийн сайдад л ер нь үндсэндээ бусад энэ байгалийн баялагтай холбоотой асуудал, тэр үнэт эдлэл, уран зурагтай холбоотой асуудал гэсэн бусад зүйлүүдээр нь холбогдох материалуудыг тухайн АНУ-ын Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсад суугаа Америкийн Элчин сайд эд нартай холбогдож албан байдлаар энэ материалуудыг татаж авах нь зүйтэй. Тийм учраас энэ чиглэлийг өгч байна. Бусад улсууд өнөөдөр яг албан байдлаар хандаж, тухайн улсын холбогдсон эрх бүхий, нэр бүхий албан тушаалтнуудынхаа талаарх мэдээллүүдийг гаргуулж аваад, өнөөдөр жишээлбэл Франц яг хууль хяналтын байгууллага шалгалтын ажил дээр явж байна, Норвег явагдаж байна, Англи явагдаж байна гээд олон улсууд өнөөдөр хууль хяналтын байгууллагын шалгалтын

ажлууд нь явагдаж байгаа учраас Монгол Улс яг энэ дагуу холбогдох материалуудыг цуглуулах чиглэлийг энэ Байнгын хорооны хурлаар, протоколоор та бүхэнд чиглэл болгоё.

Гишүүд мэдээлэлтэй холбогдуулан үг хэлж, санал хэлж дууслаа. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээллийг сонсож дууслаа.

12.21 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Байнгын хорооны хуралд оролцсон Улсын Их Хурлын эрхэм гишүүд болон Байнгын хорооны хуралдаанд мэдээлэл хийсэн холбогдох албан тушаалтнууддаа талархал илэрхийлье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА